

Эм зүйчийн /ажиллагсад/ мэргэжлээр зөвшөөрлийн шалгалтын жишиг сорил-1

Сорилын зөв хариулт

1-A, 2-D, 3-A, 4-D, 5-E, 6-B, 7-C, 8-D, 9-C, 10-C, 11-A, 12-C, 13-D, 14-E, 15-A, 16-C, 17-E, 18-D, 19-D, 20-C, 21-C, 22-C, 23-A, 24-E, 25-A, 26-B, 27-C, 28-B, 29-A, 30-C, 31-B, 32-A, 33-C, 34-D, 35-C, 36-E, 37-A, 38-B, 39-A, 40-E, 41-D, 42-C, 43-E, 44-A, 45-B, 46-C, 47-C, 48-C, 49-A, 50-A, 51-C, 52-C, 53-E, 54-D, 55-A, 56-E, 57-A, 58-C, 59-E, 60-E, 61-A, 62-A, 63-A, 64-A, 65-D, 66-B, 67-B, 68-B, 69-D, 70-E, 71-E, 72-C, 73-D, 74-A, 75-D, 76-A, 77-D, 78-C, 79-C, 80-A, 81-C, 82-E, 83-C, 84-E, 85-D, 86-A, 87-A, 88-A, 89-A, 90-E, 91-C, 92-D, 93-C, 94-A, 95-B, 96-A, 97-A, 98-C, 99-A, 100-C, 101-D, 102-B, 103-B, 104-D, 105-A, 106-A, 107-C, 108-A, 109-B, 110-B, 111-C, 112-A, 113-B, 114-E, 115-B, 116-A, 117-B, 118-A, 119-B, 120-B, 121-B, 122-D, 123-B, 124-A, 125-A, 126-A, 127-B, 128-C, 129-A, 130-A, 131-D, 132-B, 133-C, 134-A, 135-B, 136-E, 137-C, 138-D, 139-E, 140-E, 141-D, 142-C, 143-E, 144-C, 145-A, 146-C, 147-C, 148-D, 149-B, 150-C, 151-C, 152-A, 153-C, 154-B, 155-C, 156-B, 157-E, 158-A, 159-B, 160-C, 161-D, 162-D, 163-B, 164-B, 165-C, 166-A, 167-A, 168-C, 169-A, 170-C, 171-A, 172-A, 173-A, 174-D, 175-A, 176-B, 177-C, 178-D, 179-B, 180-B, 181-B, 182-C, 183-B, 184-A, 185-B, 186-C, 187-B, 188-A, 189-B, 190-C, 191-B, 192-C, 193-D, 194-D, 195-B, 196-A, 197-B, 198-E, 199-B, 200-D, 201-E, 202-A, 203-E, 204-B, 205-A, 206-B, 207-C, 208-D, 209-C, 210-C, 211-D, 212-B, 213-C, 214-B, 215-B, 216-B, 217-A, 218-D, 219-D, 220-E, 221-D, 222-B, 223-D, 224-B, 225-C, 226-B, 227-C, 228-C, 229-C, 230-A, 231-A, 232-D, 233-C, 234-D, 235-A, 236-A, 237-A, 238-D, 239-A, 240-C, 241-B, 242-A, 243-A, 244-B, 245-C, 246-A, 247-E, 248-B, 249-C, 250-A, 251-C, 252-A, 253-D, 254-C, 255-D, 256-A, 257-C, 258-E, 259-C, 260-E, 261-B, 262-A, 263-B, 264-B, 265-B, 266-A, 267-D, 268-A, 269-A, 270-C, 271-C, 272-D, 273-A, 274-E, 275-E, 276-C, 277-E, 278-C, 279-E, 280-C, 281-A, 282-A, 283-A, 284-B, 285-C, 286-C, 287-C, 288-A, 289-A, 290-B, 291-C, 292-E, 293-B, 294-A, 295-A, 296-D, 297-A, 298-E, 299-E, 300-A, 301-A, 302-A, 303-A, 304-A, 305-E, 306-E, 307-B, 308-A, 309-A, 310-A, 311-C, 312-A, 313-B, 314-E, 315-D, 316-A, 317-C, 318-A, 319-E, 320-A, 321-C, 322-A, 323-C, 324-C, 325-A, 326-B, 327-A, 328-E, 329-B, 330-C, 331-C, 332-B, 333-A, 334-C, 335-D, 336-B, 337-A, 338-B, 339-D, 340-C, 341-A, 342-B, 343-A, 344-B, 345-D, 346-E, 347-C, 348-C, 349-C, 350-C, 351-C, 352-A, 353-A, 354-A, 355-C, 356-C, 357-C, 358-D, 359-D, 360-C, 361-D, 362-B, 363-A, 364-A, 365-C, 366-C, 367-B, 368-D, 369-B, 370-E, 371-A, 372-C, 373-C, 374-C, 375-A, 376-C, 377-D, 378-A, 379-B, 380-C, 381-B, 382-A, 383-D, 384-B, 385-B, 386-A, 387-D, 388-C, 389-A, 390-C, 391-D, 392-A, 393-C, 394-A, 395-E, 396-C, 397-A, 398-A, 399-A, 400-C, 401-C, 402-E, 403-E, 404-A, 405-A, 406-A, 407-A, 408-A, 409-A, 410-A, 411-D, 412-A, 413-E,

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)
 - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (А.)
 - 1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (В.)
 - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (С.)
 - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
 - Бүх хариулт зөв бол (E.)
3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
 - Зөв, Зөв, Зөв (А.)
 - Зөв, Зөв, Буруу (В.)
 - Зөв, Буруу, Буруу (С.)
 - Буруу, Зөв, Буруу (D.)
 - Буруу, Буруу, Буруу (E.)

- /1./ Бусад хүмүүсийг удирдах эсвэл тэдэнд нөлөөлөх хүсэл шаардлагыг ямар хэрэгцээ гэх вэ?
- A. Эрхийн хэрэгцээ
 - B. Холбогдох хүчин зүйлийн хэрэгцээ
 - C. Хүндэтгэлийг эрхэмлэх хэрэгцээ
 - D. Нийгмийн хэрэгцээ
 - E. Амжилтын хэрэгцээ
- /2./ Ажлын шинжилгээг хийснээр ямар мэдээлэл олж авдаг вэ?
- A. Ажил-үр дүн
 - B. Ажил- үйл ажиллагаа
 - C. Үйл ажиллагаа-үр дүн
 - D. Ажилчид- үр дүн, ажил- үр дүн
 - E. Ажилчид-ажил
- /3./ Аливаа байгууллага өөрийгөө бүрдүүлж, өөрчлөгдөх чадвартай байх үйл ажиллагааны нөхцөл нь юу вэ?
- A. Дотоод орчин
 - B. Микро орчин
 - C. Боловсон хүчний нөөц
 - D. Гадаад орчин
 - E. Нөөц
- /4./ Байгууллага оршин тогтох хөндлөнгийн хүчин зүйлс нь юу вэ?
- A. Түнш
 - B. Өрсөлдөгч
 - C. Дотоод орчин
 - D. Гадаад орчин
 - E. Эдийн засгийн орчин
- /5./ Хувь хүмүүсийн хоорондын зөрчлийг шийдвэрлэхэд хэрэглэдэг аргуудад алийг нь оруулахгүй вэ?
- A. Буулт хийх
 - B. Зайлсхийх
 - C. Зохицуулах
 - D. Өрсөлдүүлэх
 - E. Эрх мэдлээ ашиглах
- /6./ Хэрэв гүйцэтгэл нь стандартаас дутуу байх үед менежер ямар үйл ажиллагаа явуулах вэ?
- A. Шийтгэл оногдуулах
 - B. Засварлах
 - C. Арга хэмжээ авах
 - D. Ажилчдын ур чадварыг дээшлүүлэх
 - E. Стандартаа шинэчлэх
- /7./ Манлайлагч бол удирдлагадаа байгаа хүмүүсийн хүсэл сонирхолоос шалтгаалж, тэдний зан байдлыг өөрчлөх хэрэгтэй гэсэн итгэл найдвар дээр үндэслэгдсэн онолын үзэл баримтлалд аль онол нь орох вэ?
- A. Фидлерийн загвар
 - B. Манлайллын хэлбэрийн онол
 - C. Амьдрал давтамжийн онол
 - D. Зам-зорилгын онол
 - E. Хувь хүний үүднээс хандах хандлага
- /8./ Менежментийн ухааны онолын үүднээс “Байгууллага” гэсэн ойлголтод аль нь тохирох вэ?
- A. Ашиг олох зорилготой системжсэн бүтцийг
 - B. Зохион байгуулалттай, зорилготой бүлэг хүмүүсийг
 - C. Гадаад орчны хүчин зүйлстэй уялдсан, зорилготой бүлэг хүмүүсийг
 - D. Системлэг шинж чанартай зохион байгуулалт, зорилготой бүлэг хүмүүсийн бүтцийг
 - E. Зохион байгуулалт нь зорилгыг бий болгосон системийн шинж чанартай бүлэг хүмүүсийг
- /9./ Өрсөлдөөний шинжилгээг хийхэд ашигладаг аргуудад аль нь багтах вэ?
- A. Зах зээлд шинээр орж ирэгчдийг судлах
 - B. Өрсөлдөгчийн үйл ажиллагааг судлах
 - C. Портерийн загвараар судлах

- D. Орлуулах бүтээгдэхүүн, үйлчилгээг судлах
E. Портер-Лоулериин загвараар судлах
- /10./ Удирдлагын хяналт шалгалтыг дараахи дэс дарааллаар явуулна.
A. Стандарт гаргаж, ололт, дутагдлыг илрүүлэн, авах арга хэмжээг шийдэх
B. Ажлын үр дүнг тогтоон, шалгуур стандартаар харьцуулан үзэж, ололттой дутагдалтай талуудыг гарган, түүний мөрөөр ажиллах.
C. Шалгуур стандарт тогтоож, ажлын үр дүнг түүнтэй харьцуулан үзэж, ололт дутагдалыг илрүүлэн, түүний мөрөөр авах арга хэмжээг шийдэх.
D. Ажлын үр дүнг тогтоон, ололт дутагдалыг гарган стандарт тогтоох
E. Ололт дутагдалыг илрүүлэн, стандарт гаргаж, авах арга хэмжээг шийдэх
- /11./ Өөрөө шийдвэр гаргаж, дараа нь хамт олондоо танилцуулдаг манлайлагчийн арга хэлбэрийг сонгоно уу?
A. Автократ
B. Демократ
C. Бололцоо олгон удирдах
D. Либерал
E. Классик
- /12./ Менежментийн онолын нэг төлөөлөгч Блейк-Мутоны боловсруулсан загварт “9:1” хэмжээс нь ямар утгыг илэрхийлдэг вэ?
A. Байгууллагын гишүүдийг дэмжиж, ажил хийлгэхэд бага анхаардаг.
B. Бүх түвшинд хүмүүсийн зан суртахууныг дэмжиж, ажлаа хийлгэхэд шаардлагатай зүйлийг тэнцвэржүүлж чадсанаар байгууллагын үр дүн сайн байх боломж бүрдэнэ
C. Ажлын нөхцөл байдлыг зохицуулснаар үйлдвэрлэлд үр ашгийг бий болгодог ба ажилчдад маш бага анхаарал тавьдаг.
D. Ажлын явц ба ачааллыг нөхөрсөг тохиромжтой болгон удирдах, уялдаа холбоог хангахын тулд хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг онцгой анхаардаг.
E. Өндөр чадвартай удирдагч
- /13./ Үйл ажиллагаа нь байгууллагын зорилго ба стандарттай нийцэх магадлалыг тодорхойлдог аргыг юу гэх вэ?
A. Урьдчилсан хяналт
B. Явцын хяналт
C. Буцах холбооны хяналт
D. Хяналтын систем
E. Стратегийн хяналтын систем
- /14./ Аливаа байгууллагыг зорилгод нь хүргэхийн тулд бусдыг удирдан чиглүүлж, тэдэнд нөлөөлөл үзүүлж буй хүнийг менежментийн ойлголтоор хэн гэх вэ?
A. Удирдагч
B. Менежер
C. Дарга
D. Чиглүүлэгч
E. Манлайлагч
- /15./ Хяналтын төрлүүдийг сонгоно уу?
A. Буцах холбооны хяналт
B. Явцын хяналт
C. Урьдчилсан хяналт
D. Тактикийн хяналт
E. Удирдлагын хяналт
- /16./ Өөр хэлтэс нэгжид хийгдэж байгаа тодорхой үйл явц, үйлдэл, бодлого бусад төрлийн үйл ажиллагааг хянах талаар нэг ажилтанд буюу нэг нэгжид олгосон эрх мэдлийг юу гэдэг вэ?
A. Шугаман эрх мэдэл
B. Түшиг эрх мэдэл
C. Функциональ эрх мэдэл
D. Эрх мэдлийг төвлөрүүлэх
E. Шилжсэн эрх мэдэл

/17./ Тодорхой нэгэн нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэхийн тулд үйл ажиллагаагаа ухамсартайгаар хослуулан нэгтгэсэн хүмүүсийн бүлгийг юу гэж ойлгох вэ?

- A. Бүлэг
- B. Хэсэг
- C. Нэгдмэл бүлэг
- D. Бүлэглэл
- E. Байгууллага

/18./ Байгууллага доторхи хүмүүсийн бүлгийг ямар үндсэн хэсэгт хуваах вэ?

- A. Сонирхоллын ба нөхөрлөлийн
- B. Үйл ажиллагааны ба ажил төрлийн
- C. Тогтмол ажлын бүлэг ба түр зуурын ажлын бүлэг
- D. Албан ба албан бус
- E. Зорилтот ба зорилтот бус

/19./ Манлайллын асуудалд зан байдлын үүднээс хандах хандлагад багтах категориыг сонгоно уу?

- A. Мэдлэг ба харилцаа холбоо
- B. Хүний дотоодыг танин мэдэх
- C. Хувь хүний зан байдлыг мэдэх
- D. Хамт олныг дэмжих ба туслах
- E. Хамт олныг ойртуулах

/20./ Гадаад хүчин зүйлсийн микро орчинд аль нь багтах вэ?

- A. Хүн ам зүйн орчин
- B. Эдийн засгийн орчин
- C. Өрсөлдөгчид
- D. Улс төр, эрх зүйн орчин
- E. Байгаль, экологийн орчин

/21./ Гүйцэтгэх ажил үүргүүдийн хооронд нөөцүүдийг хуваарилах ба тэдгээрийн өрсөлдөөнийг илэрхийлдэг ойлголтыг юу гэдэг вэ?

- A. Эрхэм зорилго
- B. Нөөц хувиарлалт
- C. Нөөц ашиглалт
- D. Ажил үүргийн стратеги
- E. Дотоод нөөцийн шинжилгээ

/22./ Менежментийн 5 функцыг баяжуулж, менежерийн үйл ажиллагааны үндсэн 10 үүргийг тодорхойлсон судлаач хэн бэ?

- A. Ф.Тейлор
- B. А.Файоль
- C. Х.Менцберг
- D. Х.Бернард
- E. А.Маккинэн

/23./ Хүмүүсийг сонгож ажилд авах, тэднийг дадлагажуулах, ажлын нөхцөл ба цалин хөлсийг зохимжтой хэмжээнд хангах болон шаардлагатай үед эдгээр асуудлын талаар Үйлдвэрчний эвлэлтэй гэрээ байгуулах, удирдлага ажилчдын хоорондын харилцааг хэвийн байлгахад чиглэгдсэн үйл ажиллагааг юу гэдэг вэ?

- A. Хөдөлмөрийн нөөцийн удирдлага
- B. Нөөцийн удирдлага
- C. Ажиллах хүчний удирдлага
- D. Хөдөлмөрийн үйл ажиллагааны удирдлага
- E. Ажил төлөвлөлтийн удирдлага

/24./ Маслоугийн хэрэгцээнд нь тулгуурлан хүнийг идэвхижүүлэх онолын үзэл баримтлалын "Пирамид" загварын суурь хэрэгцээ нв аль вэ?

- A. Амжилтын хэрэгцээ
- B. Өөрийгөө хамгаалах хэрэгцээ
- C. Нийгмийн хангамжийн хэрэгцээ
- D. Эрх мэдлийн хэрэгцээ
- E. Физиологийн хэрэгцээ

/25./ Удирдлагын шийдвэр гаргах явцад менежерт мэдээлэл хангалтгүй байх нь юу гэсэн үг вэ?

- A. Аз туршилт хийх
- B. Асуудлын шинж байдлын бүрдэлт муу
- C. Тодорхойгүй байдал
- D. Асуудлын мэдээллийн хомсдол
- E. Удирдлагын шийдвэрийн онцлог

/26./ Байгууллагын төлөвлөлтийг боловсруулсан хэмжээнд хэрэгжүүлэх явдлыг баталгаажуулах ба байгууллагын хэтийн үйл ажиллагааг тодорхойлох, төлөвлөлтөнд хүчтэй нөлөөлөх орчны гол хүчин зүйлсийг хянах үйл ажиллагааг юу гэдэг вэ?

- A. Тактикийн хяналт
- B. Стратегийн хяналт
- C. Үйл ажиллагааны хяналт
- D. Хэтийн болон дунд хугацааны хяналт
- E. Ойрын болон дунд хугацааны хяналт

/27./ Байгууллагын стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үндсэн аргын шат дарааллыг зөв тогтоо

- A. Дэс дарааллаа тогтоон, тактикаа сонгож, бодлогоо
- B. Тактикаа сонгож, бодлогоо боловсруулж, хэрэгжүүлэх дэс дарааллаа тогтоож, дүрэм журам гарган мөрдөх.
- C. Бодлогоо боловсруулж, тактикаа сонгон, дүрэм журмаа гарган, дэс дарааллаа хэрэгжүүлэх
- D. Дэс дарааллаа тогтоон, бодлогоо боловсруулж, дүрэм журмаа гарган, тактиктэй хэрэгжүүлэх
- E. Дүрэм журмаа гарган, дарааллаа тогтоон, бодлого боловсруулж, тактикаа сонгох

/28./ Байгууллагын ажилчид нь өөрсдийгөө илэрхийлэх, нийгмийн болон аюулгүй байдлын хэрэгцээгээ хангахын тулд бүлэг байгуулах шалтгаант аль нь орох вэ?

- A. Эдийн засгийн шалтгаан
- B. Нийгэм, сэтгэл зүйн шалтгаан
- C. Бодит шалтгаан
- D. Нийгмийн шалтгаан
- E. Сэтгэл зүйн шалтгаан

/29./ Удирдагч нь шийдвэр гаргалтанд ганцаар ноёрхох, бусдын санаа бодлыг зөвшөөрөхгүй байх явдлаас зайлсхийх хэрэгтэй. Яагаад гэвэл бүлгийн гишүүдийн санаа бодлыг урамшуулах нь зөв шийдвэр гаргахад онцгой ач холбогдолтой байдаг

/30./ Бүлгийн гишүүдийн тоог 10-15 хүн байх нь хамгийн тохиромжтой байдаг. Яагаад гэвэл цөөн хүнтэй бүлэгт шийдвэр гарахад хүлээх хувийн хариуцлага өндөр байдаг, олон хүнтэй бүлэгт гишүүд өөрийн санаа бодлоо илэрхийлэхэд хүндрэл үүсч, зөвшилцөхөд илүү бэрх болдог

/31./ Хяналтын функц нь асуудлыг илрүүлэх ба эдгээр асуудлыг хямрал болон даамжирахаас өмнө байгууллагын үйл ажиллагааны хамт засч залруулах боломж олгодог удирдлагын хүчин зүйл юм. Яагаад гэвэл хяналтын системийг боловсруулснаар орчны өөрчлөлтийн талаархи мэдээллийг авч тодорхойгүй байдлыг багасгадаг.

/32./ Эмийн чанарын менежер дараах үйл ажиллагааг эрхэлнэ.

1. Эмийн чанарын баталгаажуулалт, хадгалалт, чанарын хяналт тавьж хүлээн авсан бүх эмийн хүчинтэй хугацаа болон чанарын баталгаажилтын бүртгэл хөтөлнө
2. Эм ханган нийлүүлэх байгууллагын үйл ажиллагааны дотоод дүрэмд заагдсны дагуу бүх шат дамжлагад хяналт тавина
3. Жин, хэмжих бусад хэрэгсэл нь баталгаажуулагдсан, графикийн дагуу тохируулга хийгдсэн эсэхэд хяналт тавина
4. Тээвэрлэлтийн явцад хагарсан, асгарч холилдсон, хадгалалтын явцад чанар нь муудсан эмийг актална

5. Эмийн үйлдвэрлэлийн сертификатыг шалгана
- /33./ Өвчтөнд олгох эм, биобэлдмэл дараах мэдээллийг агуулсан хаяглалттай байна
1. Эм, биобэлдмэлийн хүчинтэй байх хугацаа
 2. Эм, биобэлдмэлийн нэр
 3. Эм, биобэлдмэлийн орос, монгол нэр
 4. Хэрэглэх арга
 5. Үйлдвэрлэсэн улсын код
- /34./ Эм найруулгын өрөөны тавилга төхөөрөмж, материал хэрэгслийн байршил, эм найруулагчийн хийх үйлдэл нь хэдээс хэдэн градусуас дээшгүй тонгойхоор байх ёстой вэ?
1. 15
 2. 30
 3. 25
 4. 20
 5. 35
- /35./ Эмийн хэрэгцээг тодорхойлохдоо нийт эмүүдийг хэд хэдэн бүлэгт хувааж хэрэгцээг тооцож болно. Аль нь зөв вэ?
1. Тасалдалтай байгаа эмүүдийн
 2. Өргөн хэрэгцээний эмүүдийн
 3. Хэрэглээнд шинээр нэвтэрч байгаа эмүүдийн
 4. Мансууруулах, өвөрмэц үйлдэлтэй, нормчлогдсон эмүүдийн
 5. Ховор өвчинд хэрэглэгддэг эмүүдийн
- /36./ Улсын бүртгэлд бүртгүүлэх эм нь дор дурдсан нөхцлийг хангасан байна. Үүнд:
1. Найрлага нь нарийвчлан тогтоогдсон
 2. Үйлдэл нь бүртгэгдсэн ижил төстэй эмийнхээс давуу, гаж нөлөө харилцан үйлчлэл багатай
 3. Монгол улсын эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэж байгаагүй үйлчлэгч бодис бүхий эм нь гадаадын 3-аас доошгүй улсад бүртгэгдсэн
 4. Гарал үүслийн улсын эмийн бүртгэлд бүртгэгдээд 3-аас доошгүй жил болсон
 5. Эмийн хэрэглэх заавар, шошго нь Монгол, Англи эсвэл Орос хэл дээр байна
- /37./ Эм барих гэж юуг хэлэх вэ?
1. Эм зүйн шинжлэх ухааны дагуу эмийг найруулах
 2. Эм зүйн шинжлэх ухааны дагуу эмийг савлан бэлтгэх
 3. Эм зүйн шинжлэх ухааны дагуу эмийг шалгаж олгох
 4. Эм зүйн шинжлэх ухааны дагуу эмийг хаяглах
 5. Эм зүйн шинжлэх ухааны дагуу эмийг хадгалах
- /38./ Үнэ төлбөргүй эмчилгээг аль өвчний тохиолдолд хийх вэ?
1. Сүрьеэ
 2. Хорт хавдрын III, IV үе шат (хөнгөвчлөх эмчилгээ)
 3. Сэтгэцийн эмгэг
 4. Оюуны хомсдол (F7.0 – F7.9)
 5. Нөхөн сэргээх эмчилгээ
- /39./ Хаягдлыг ялгасны дараа савлах уут, хайрцгийг өнгөөр ялгаж төрөлжүүлнэ. Үүнд:
1. Ердийн хаягдалыг хар өнгийн уут, саванд хийнэ.
 2. Эмнэлэг- үйлчилгээний хог хаягдлыг шар өнгийн уут, саванд хийж олон улсын биологийн болон халдвартай хог хаягдлыг таних тэмдгийг тавина.
 3. Хими цацраг идэвхитэй, эсэд хортой нөлөө үзүүлдэг хаягдлыг хүрэн өнгийн уут, саванд хийж, тус тусын таних тэмдэг тавина.
 4. Халдварын зэрэглэл өндөртэй хаягдлыг цагаан өнгийн уут, саванд хийж халдвартай гэж бичнэ.
 5. Щприц зэргийг улаан уутанд хийнэ
- /40./ Уламжлалт эмийн үйлдвэр үйл ажиллагаанаасаа хамааран дараах тасаг өрөөтэй байна. Үүнд:
1. Уламжлалт тан, үрэл зэхмэл эмийг боох савлах
 2. Уламжлалт тан, үрэл, талх эм үйлдвэрлэх /нунтаглах-шигших- холих/
 3. Ханд хэлбэрийн бэлдмэл үйлдвэрлэх /хандлах, шүүх, ханд нэрэх, өтгөрүүлэх, савлах, ус нэрэх, шил сав угаах, ариутгах /

4. Номхотгох буюу дахин боловсруулалт хийх, эмийн ургамал угаах, цэвэрлэх, холтослох үйл ажиллагаа явуулах

5. Эмт бодис, эцсийн бүтээгдэхүүн, туслах материал хадгалах, эхний материал бэлтгэх, боловсруулах

/41./ Анагаах ухааны орчин үеийн ёс зүйн онолын үндсэн үзэл баримтлалд аль нь хамаарах вэ?

1. Зах зээлийн үзэл баримтлал
2. Эртний үзэл баримтлал
3. Өнөө үеийн үзэл баримтлал
4. Орчин үзэл баримтлал
5. Консивинциаль онол

/42./ Эмийн үйлдвэрт үйлдвэрлэж савлагдсан бүтээгдэхүүн нь дараах хаягтай байна

1. Бүтээгдэхүүний олон улсын нэр
2. Хүчинтэй нөхцөл
3. Хүчинтэй хугацаа
4. Тусгайласан анхааруулга
5. Хэрэглэх заавар тусгайлсан анхааруулга

/43./ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг дор дурьдсан зорилгоор дараахь байгууллага ашиглаж болно.

1. Эмчилгээ, шинжилгээ, судалгааны зорилгоор эмнэлэг
2. Лабораторийн шинжилгээ хийх зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих үүрэгтэй байгууллага
3. Харьцуулалт хийх, зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн үйл ажиллагааг илчлэх зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллага;
4. Эмчилгээ, шинжилгээ, судалгааны зорилгоор эрдэм шинжилгээний байгууллага
5. Сургалт явуулах зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих үүрэгтэй байгууллага

/44./ Ариун эмийн үйлдвэрлэлийн байрны агаарын цэвэршилтийн "А" ангиллыг сонгоно уу?

1. 0.5 – 5µm/микромметр/-3500
2. 5µm/микромметр-1;
3. 1м3 агаарт байж болох нянгийн зөвшөөрөгдөх хамгийн их тоо -1-ээс бага
4. 0.5 – 5µm/микромметр/-35000; 5µm/микромметр-1; 1м3 агаарт байж болох нянгийн зөвшөөрөгдөх хамгийн их тоо -1-ээс бага;
5. 0.5 – 5µm/микромметр/-3500; 5µm/микромметр-1;

/45./ Хандив тусламжийн эмнэлгийн хэрэгсэл нь дараах шаардлагыг хангасан байна.

1. Зэвэрч хуучирч муудаагүй, эмнэлэг, эмийн сан, бусад байгууллагаас буцаагдаагүй байх
2. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын чанарын сертификаттай схемтэй байх
3. Хүчинтэй байх хугацаа нь 1-1.6 жилээс доошгүй байх
4. Тээвэрлэлтэд зориулсан савлагаа нь олон улсын ачаа бараа тээвэрлэх шаардлагыг хангасан
5. Чанарын ямар нэгэн доголдол гараагүй байна.

/46./ Эм барааны нөөцийн тасгийн эрхлэгч нь дараах бүртгэлүүдийг хөтөлнө

1. Найруулсан эмийн бүртгэл
2. Эм барааны нэр төрлийн карт
3. Жорын бүртгэл
4. Хугацаат эмийн бүртгэл
5. Эм барааны бүртгэл

/47./ Эм үйлдвэрлэгчдийн хувцаслалтын D – зэргийг сонгоно уу?

1. Цамц нь өндөр захтай
2. Үс, сахлыг ил гаргахгүйгээр битүү далдална
3. Ханцуйны гарын шуу талын төгсгөл хумигдсан
4. Хамгаалалтын хувцас, тэдгээрт тохирсон гутал, эсвэл гутлын гадуурх өмсгөл өмссөн
5. Пластик бээлий өмссөн

/48./ Эмийн түгээлтийг онолын хувьд хэдэн түвшинд хуваадаг вэ?

1. Улс хоорондын
2. Бүсийн

3. Аймгуудын
4. Олон улсын
5. Сумын

/49./ Эмийн үндэсний зөвлөл нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1. Эмийн үндэсний бодлогын асуудлаар санал, зөвлөмж боловсруулж, төрийн захиргааны холбогдох төв байгууллагад оруулах
2. Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалтад өөрчлөлт оруулах талаар санал боловсруулах
3. Эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах
4. Мансууруулах болон сэтгэц нөлөөт эмийн жагсаалтыг батлах
5. Эмийн улсын стандарт, фармакопег батлах

/50./ Эм үйлдвэрлэлийн эхний материалд тавигдах шаардлагуудыг сонгоно уу?

1. Хангагч байгууллагаас нийлүүлсэн эхний материалын савлалтын бүрэн бүтэн байдал, лац тэмдэг, захиалга, нийлүүлэлтийн мэдэгдэл ба хангагчийн хаяг зэрэг нь хоорондоо тохирч буйг шалган огноо бичмэл хаяг нааж, баримтжуулна.
2. Үйлдвэрлэлд эхний материал нь GMP – н шаардлага хангасан үйлдвэрлэгчийн чанарын сертификаттай, эрх бүхий байгууллагын итгэмжлэгдсэн лабораториор баталгаажсан байна.
3. Хадгалах онцгой температур, чийг болон тусгай нөхцөл шаардагддаг материалыг горимын дагуу хадгалан, шалгаж тэмдэглэл хөтлөнө.
4. Мансууруулах, сэтгэц нөлөөт эм, цацраг идэвхит бодис, тэсэрч дэлбэрэх материал болон бусад хор хөнөөл ихтэй зүйлс хүлээн авах, хадгалах, тэдгээртэй ажиллахдаа бүртгэл хөтөлнө.
5. Эхний материалыг зөвхөн яанарын менежерийн хяналтан дор агуулахаас гаргаж, жинлэлтийг хянаж бүртгэнэ.

/51./ Монгол улсын эмнэлгийн практикт хэрэглэх мансууруулах, сэтгэц нөлөөт болон хүчтэй үйлдэлтэй эмийн жагсаалтын мансууруулах эмийн бүлэгт багтах эмүүдийг сонгоно уу?

1. Галоперидол
2. Трамадол
3. Нитрозепам
4. Петидин
5. Фентазин

/52./ Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлтийн технологийн шаардлагыг хангаагүй нөхцөлд үйл ажиллагаа явуулбал албан тушаалтан, байгууллагад ямар торгууль ногдуулах вэ?

1. 15000-25000, 50000-100000₮
2. 10000-20000₮
3. 150000-250000₮
4. 100000-200000₮
5. 10000-20000, 100000-300000₮

/53./ Эмнэлгийн эмийн эмчилгээг зохицуулах хороо дараах үүрэг хүлээнэ:

1. Эмнэлгийн эмч, мэргэжилтэн, үйлчлүүлэгчдэд шинэ эм хэрэглэх, эмийн талаар үнэн зөв, бодит мэдээллээр хангах, тэдний эмийн хэрэглээний талаархи мэдлэгийг дээшлүүлэх, сургалт зохион байгуулах;
2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардагдах эмийн жагсаалтыг гаргах, сонголтын талаар зөвлөх;
3. Байгууллагын онцлогт тохирсон эмийн лавлах тогтмол гаргах, эмчилгээний удирдамж (стандарт) боловсруулахад эмч, мэргэжилтэнд туслах;
4. Эмийн гаж нөлөөг бүртгэх, тандах, үнэлгээ өгөх, мэдээлэх, сэргийлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах;
5. Жорын маягт, жор бичилтийн стандартын мөрдөлт, жорын маягтын хангалт, хүртээмж, жор бичилтийг оновчтой болгоход чиглэсэн арга хэмжээ зохион байгуулан, хяналт тавьж ажиллах;

/54./ Эмийн сан нь Дигоксин тариаг хэрэглэгчдэд хэрхэн олгох вэ?

1. Эмчийн жороор
2. Жоргүйгээр
3. Эмийн санчийн шийдвэрээр

4. Стационарт
5. Өрхийн эмчийн шийдвэрээр

/55./ Эм ханган нийлүүлэх байгууллагын мэргэжлийн ажилтны бүрэлдэхүүн дараах доод хязгаарыг хангасан байна

1. Эм худалдааны менежер – Эм зүйч
2. Эмийн чанарын менежер – Эм зүйч
3. Бэлтгэгч, олгогч - Эм зүйч эсвэл эм найруулагч
4. Захиалга хүлээн авагч - Эм зүйч
5. Олгогч-Эм найруулагч

/56./ Дараах эмийн бэлдмэлийг бүртгэлд бүртгэнэ. Үүнд:

1. Монгол улсын эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэж байгаагүй үйлчлэгч бодис бүхий эм

2. Эмийн бүртгэлд бүртгэгдээгүй эм
3. Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн уламжлалт эм тан
4. Хоногийн дээд тун нь эмчилгээний тун бүхий аминдэм, эрдсийн бэлдмэл
5. Үндсэн үйлчлэгч бодис болон туслах бодис өөрчлөгдсөн бүртгэлтэй эм

/57./ Эмийн мэдээлэл сурталчилгаа ямар байх ёстой вэ?

1. Үнэн
2. Зөв
3. Бодит
4. Үйлдэл, үр дүнг магтсан
5. Үнэ боломжийн болохыг сурталчилсан

/58./ Хүлээн авагчаас буцаасан эм нь дор дурдсан шаардлагыг хангасан нөхцөлд эм хадгалах үндсэн хэсэгт шилжүүлж болно

1. Буцаагдсан бараа зохих журмын дагуу хадгалагдаж байсныг нотлох бичигтэй
2. Өөрийн анхны савалгаанд задрал гэмтэлгүй байгаа
3. Буцаагдсан эмийн чанар нь шаардлагад тохирч буй нь холбогдох бичиг баримтаар батлагдаж байгаа
4. Хүчинтэй хугацааны үлдсэн хугацаа нь 1/3-ээс хэтрээгүй
5. Буцаагдсан эмийн чанар нь фармакопейн шаардлагад тохирч буй нь холбогдох бичиг баримтаар батлагдаж байгаа

/59./ Эрүүл мэндийн санхүүжилт нь ямар эх үүсвэрээс бүрдэх вэ?

1. Иргэний эрүүл мэндийг хамгаалах тусгай сан
2. Улс, орон нутгийн төсөв
3. Байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, иргэний хандив
4. Эрүүл мэндийн даатгал
5. Гадаадын зээл, тусламж

/60./ Эм ханган нийлүүлэх байгууллага нь дараах нэгжтэй байна.

1. Удирдлага
2. Захиалга хүлээн авах, олгох
3. Бэлтгэн нийлүүлэх
4. Агуулах
5. Чанарын хяналт

/61./ Эм биобэлдмэлийн жорын ач холбогдол нь юу вэ?

1. Санхүүгийн
2. Хуулийн
3. Анагаах ухааны
4. Эмийн чанарын
5. Эмийн технологийн

/62./ Нийлмэл эмийн жорыг бичих дараалалыг сонгоно уу ?

1. basis adjuvans
2. adjuvans
3. corrigens
4. basis
5. basis corrigens

/63./ Эмийн үйлдвэрлэл эрхлэхэд хориглох зүйлийн талаар эмийн тухай хуульд юу гэж заасан бэ?

1. Эмийн бүртгэлд бүртгэгдээгүй эм үйлдвэрлэх
2. Хүний зориулалттай эмийг мал, амьтны зориулалттай эмтэй нэг дамжлага дээр үйлдвэрлэх
3. Хүний зориулалттай эмийг мал, амьтны зориулалттай эмтэй нэг шугам дээр үйлдвэрлэх
4. Эмийн бүртгэлд бүртгэгдсэн эм үйлдвэрлэх
5. Дууриамал болон хуурамч эмийг үйлдвэрлэхгүй байх

/64./ Эмийн зохистой хэрэглээнд оролцдог 3-н үндсэн элементийг сонгоно уу?

1. Эмч
2. Өвчтөн
3. Эм зүйч
4. Сувилагч
5. Хүн ам

/65./ Эмийн санг зөв байрлуулахад дараах үндсэн зарчмийг тооцож үзнэ.

1. Эмийн нэр төрөл
2. Эмийн мэдээлэл сурталчилгааны асуудал
3. Дэвсгэр нутгийн хүн амын бүтэц
4. Эмийн сангийн үйлчилэх хүн амын тоо
5. Найруулж буй эмийн тоо

/66./ Дараах эмүүдээс жороор олгох эмийг сонгоно уу?

1. Циметидин тарилгын уусмал, шахмал
2. Циннаризин, шахмал
3. бойгар 10
4. Гарьд 13
5. Лидокайн

/67./ Иргэний хувийн хэрэглээнд зориулан Монгол улсын хилээр оруулахыг хориглох эмийн нэр төрөл

1. Сүрьеэ эмчлэх эм
2. Антибиотик /тариа/
3. Вакцин
4. Цус сэлбэх шингэн
5. Өнчин эм

/68./ Эмийн үйлдвэрийн чанарын хяналт хариуцсан менежер нь тухайн үйлдвэрлэлийн чиглэлийн дагуу мэргэшсэн эрх бүхий эм зүйч байх ба дараах үүргийг хүлээнэ.

1. Чанарын хяналтын бүх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, баталгаажуулах, чанарын баталгааг хангана

2. Цувралын бүртгэлд үнэлгээ өгнө
3. Шаардлагатай бүх шинжилгээг хийх баталгааг буй болгох нөхцлөөр хангана.
4. Дээж авах зааварчилгааг боловсруулна
5. Үйлдвэрлэлийн байр ба тоног төхөөрөмжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ашиглана

/69./ Мансууруулах, сэтгэц нөлөөт болон хүчтэй үйлдэлтэй эмийг гэрээр олгох тохиолдолд хэний гарын үсэгтэй жороор олгох вэ?

1. Эмчлэгч
2. Эмийн сангийн эрхлэгч
3. Эмнэлгийн дарга
4. Ерөнхий эмч
5. Өрхийн эмч

/70./ Эмийн үйлдвэрийн зарим онцгой аюултай материалын дээж авах үйл ажиллагаанд тусгай сэрэмжлүүлэг шаардана. Дээж авсан сав бүр дараах хаягтай байна.

1. Дээж болон савлагдсан материалын нэр
2. Цувралын дугаар
3. Дээж авсан савны дугаар
4. Дээж авсан хүний гарын үсэг
5. Дээж авсан он сар өдөр

/71./ Эмнэлгийн мэргэжилтэн дор дурьдсан үүрэг хүлээнэ.

1. Эмнэлгийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг биелүүлнэ
2. Хүнлэг энэрэнгүй үзлийг эрхэмлэнэ
3. Мэргэжлээ хүний эрүүл мэндийн эсрэг ашиглахгүй
4. Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, сургалт, сурталчилгаа явуулах, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх

5. Иргэний эрүүл мэндийн болон байгууллагын нууцыг хадгалах

/72./ Эмнэлгийн мэргэжилтэн нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээгүл ялгаварлан тэгш, хүртээмжтэй үзүүлнэ.

1. Намын үзэл
2. Улс төрийн үзэл
3. Ажил
4. Шашин шүтлэг
5. Ажил мэргэжил

/73./ Ямар эмийг импортлох вэ?

1. Эмийн улсын бүртгэлд бүртгэгдэх гэж байгаа эмийг
2. Яаралтай тусламжинд шаардлагатай эмийг
3. Улсын бүртгэлд бүртгэгдсэн эмийг
4. Ховор тохиолддог өвчнийг эмчлэхэд харьцангуй бага хэмжээгээр хэрэглэгддэг эм /өнчин эм/
5. Төлбөргүй тусламжийн эмийг

/74./ Эмийн санд нэвтэрч буй шинжлэх ухааны хөдөлмөр зохион байгууллалтын үр дүн нь дараах үзүүлэлтүүдийн сайжралтаар илэрхийлэгдэнэ

1. Эмийг бэлтгэх хугацааны багасалт
2. Бэлэн хэлбэрийн эмийн эзлэх хувийн ихсэлт
3. Үйлчлүүлэгсэдийн эм авах хүлээлтийн хугацааны багасалт
4. Эмийн нэр төрлийн багасалт
5. Эм бэлтгэх ажилтны тооны ихсэлт

/75./ Эмийг найруулах бүртгэх болон эмийн чанарыг шалгах аргыг заасан зайлшгүй мөрдөх стандартын түүврийг юу гэдэг вэ?

1. Эмийн стандарт
2. Эмийн үнэлэмж
3. Эмийн улсын бүртгэл
4. Фармакопей
5. Эмийн чанарын стандарт

/76./ ДЭМБ-аас мөрддөг эм сонголтын шалгуурт доорхи хувилбаруудын аль нь багтах вэ?

1. Эмнэлгийн тусламжийн янз бүрийн түвшинд хэрэглэж болохоор байх
2. Элдэв гаж нөлөө багатай байх
3. Үнэ хямд байх
4. Өвчтөн уух боломжтой байх
5. Улсын бүртгэлд бүртгэгдсэн байх

/77./ Ямар хилийн боомтоор эмийг оруулж ирэхийг зөвшөөрдөг вэ?

1. Алтанбулаг, Буянт-Ухаа, Замын-Үүд, Өлгий, Сүхбаатар, Цагааннуур, Эрээнцавын зэрэг ажиллагаатай боомтоор
2. Буянт-Ухаа, Замын-Үүд, Өлгий, Сүхбаатар, Цагааннуур, Алтанбулаг, Эрээннуурын зэрэг байнгын ажиллагаатай боомтоор
3. Алтанбулаг, Буянт-Ухаа, Замын-Үүд, Баян-Өлгий, Сүхбаатар, Цагааннуур, Гашуун сухайтын зэрэг байнгын ажиллагаатай боомтоор
4. Алтанбулаг, Буянт-Ухаа, Замын-Үүд, Өлгий, Сүхбаатар, Цагааннуур, Эрээнцавын зэрэг байнгын ажиллагаатай боомтоор
5. Сүхбаатар, Цагааннуур, Алтанбулаг, Буянт-Ухаа, Замын-Үүд, Өлгий, Гашуун, Эрээнцавын зэрэг байнгын ажиллагаатай боомтоор

/78./ Үндэсний зайлшгүй шаардлагатай эмэнд хийдэг шинжилгээний аргыг сонгоно уу?

1. АВГ шинжилгээ
2. АВС шинжилгээ
3. VЕН шинжилгээ
4. VEN шинжилгээ

5. ҮҮН шинжилгээ

/79./ Ургамлын гаралтай эмийн түүхий эдийг дараахь нөхцөлд хадгална.

1. Эфирийн тос агуулсан эмийн ургамлын түүхий эдийг сайн саванд тусад нь хадгална
2. Урьдчилан хатаасан эмийн ургамлын түүхий эдийг хуурай, агааржуулалт сайтай байранд цаасан болон тохирох саванд хадгална.
3. Хатаасан эмийн ургамлын түүхий эдийг битүү шилэнд хадгална.
4. Мансууруулах болон сэтгэц нөлөөт үйлдэлтэй ургамлын түүхий эдийг тусгаарласан байранд эсвэл тусгай цоожтой шүүгээнд хадгална.
5. Мансууруулах үйлдэлтэй ургамлын түүхий эдийг эрхлэгчийн зөвшөөрлөөр зарцуулна

/80./ Эмийн санд бэлтгэсэн эмийн бэлдмэл нь эмийн сангийн дараах дотоод хяналт шалгалтанд хамрагдана.

1. Бичгийн
2. Мэдрэхүйн эрхтэний
3. Асуух
4. Зөвхөн амтлах
5. Олгох үеийн хяналт

/81./ Хандив, тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийг хэрхэн зарцуулах вэ?

1. Хандив, тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийг зориулалтаар хэрэглэхийг эрхэмлэнэ.
2. Хандив, тусламж хүлээн авагч байгууллага нь эм, эмнэлгийн хэрэгслийн эргэлтийн хөрөнгөдөө бүртгэн авч ашиглалтад хяналт тавьж байна.
3. Хандив, тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийг зарж борлуулахгүй.
4. Хандив, тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийг зөвхөн эмнэлгийн өвчтөний хэрэгцээнд зарцуулна
5. Хандив, тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийг мэргэжлийн хяналтын байгууллага хянаж байна.

/82./ Төлбөрийг нь төрөөс дааж амбулатори, поликлиникээр үнэ төлбөргүй олгох эмийн жагсаалтад багтах эмүүдийг сонгоно уу?

1. Хлорпромазин (шахмал, 100 мг, гидрохлорид)
2. Галоперидол (шахмал, 2 мг, 5 мг)
3. Флуфеназин (шахмал, 10, 20 мг, деканоат)
4. Диазепам (шахмал, 2 мг, 5 мг)
5. Амитриптилин (шахмал, 10 мг)

/83./ Аль ч зэрэглэлийн эмийн санд хориглох зүйлүүд

1. Соёлын болоод гоо сайхны бараа худалдаалах
2. Эмийн хэлбэрүүдийг үйлдвэрлэх
3. Усан уусмал найруулан бэлтгэх
4. Галены бэлдмэл үйлдвэрлэх
5. Бөөн эмийг жижиглэн савлаж худалдаалах

/84./ Эмийн үйлдвэрийн үйл ажиллагааны баримтжуулалт нь дараах бүртгэлээс бүрдэнэ. Үүнд:

1. Эхний материалыг хүлээн авсан бүртгэл
2. Дамжала дундын хяналтын бүртгэл
3. Үйлдвэрлэлийн цувралын бүртгэл
4. Эцсийн бүтээгдэхүүнийг худалдаанд гаргасан бүртгэл
5. Зах зээлээс буцан татсан бүтээгдэхүүний бүртгэл

/85./ Консивинциаль онолын үзэл баримтлал нь юу вэ?

1. Үйлдэл, үйл ажиллагааны зөв буруу нь түүнийг төрүүлсэн сэдлээс (санаатай ба санамсаргүй үйлдэл) хамаарна
2. Ухамсарласнаас үйлдлийг хийж байна уу, эсвэл айснаас хийж байна уу гэдгээс хамаарна.
3. Үйлдэл, үйл ажиллагааны зөв буруу нь түүнийг төрүүлсэн сэдлээс (санаатай ба санамсаргүй үйлдэл) хамаарахгүй байх.
4. Үйлдэл, үйл ажиллагааны үр дүн нь учруулах хохирлоос их байна гэвэл зөв, бага байвал буруу байна гэж үздэг онолын үзэл баримтлал.
5. Үйлдэл нь учруулах хохирлоос их байна гэвэл зөв, бага байвал буруу байна гэж үздэг онолын үзэл баримтлал юм.

/86./ Ариун эм үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэдэн зэрэглэлд хуваах вэ?

1. Бэлдмэлийг эцсийн саванд савлаж битүүмжлэн ариутгадаг
2. Бэлдмэлийг шүүх аргаар ариутгадаг
3. Бэлдмэлийг шүүх аргаар болон дулааны аргаар ариутгаж болдоггүй, зөвхөн үжилгүй нөхцөлд ариутгасан эхний материалаар бэлтгэдэг.
4. Бэлдмэлийг шүүдэг
5. Бэлдмэлийг үөвхөн дулааны аргаар хийдэг.

/87./ Эм хангамжийн байгууллага нь дараахь нийтлэг үүргийг хүлээнэ

1. Эм ханган нийлүүлэх байгууллага нь эм, эмнэлгийн хэрэгслээр эрүүл мэндийн байгууллагыг ханган нийлүүлнэ
2. Эмийн сан, түүний салбар нь эм, эмнэлгийн хэрэгслийг эрүүл мэндийн байгууллага, мал эмнэлэгд жижиглэн худалдаална
3. Эм хангамжийн байгууллага нь шаардлагыг хангасан байна
4. Эм хангамжийн байгууллага нь ашиг орлогоо нэмэгдүүлэхийн зорилгоор эмнэлгийн мэргэжилтнийг эм, эмнэлгийн хэрэгсэл борлуулах, үр дүнгээр нь урамшуулах буюу түүнийг адилтгах үйл ажиллагаанд оролцуулахыг хориглоно.
5. Хуурамч эм импортлох, үйлдвэрлэх, худалдана.

/88./ “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн журам”-д эмнэлгийн мэргэжилтэн нь ямар эм худалдахыг хатуу хориглоно гэж заасан бэ?

1. Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй
2. Үр дүнгийн талаар тодорхойгүй
3. Стандартын зохих шаардлага хангаагүй
4. Үйлдвэр нь тодорхой биш
5. Үнэ өндөр

/89./ Хөдөлмөр зохион байгуулалт, хөдөлмөрийн үйл ажиллагааг дараах аргуудаар судална.

1. Ажлын цагийн зарцуулалтаар судлах
2. Ажиллагсадын өвчлөлийг эмнэлгийн хуудас ба эрүүл мэндийн үзлэгээр судлах
3. Тохиолдлыг ажиглан бүртгэх
4. Шинжилгээний аргууд
5. Ажлын цагийн бүртгэлээр судлах

/90./ Эмийн сангийн ажил олгогч нь ажилтантайгаа ажлын байр, хөдөлмөрийн нөхцөл, гүйцэтгэх ажил үүргийн талаар хөдөлмөрийн гэрээг амаар байгуулна. Яагаад гэвэл ажилтны ажлын байр, гүйцэтгэх ажил үүрэг байнга өөрчлөгдөж байдаг

/91./ Эмнэлгийн эмийн сан тарилгын шингэн бэлтгэж болно. Учир нь эмнэлгийн бүх эмийн сангуудад үүнийг зөвшөөрдөг.

/92./ Эмийн санд эм шинжлэгчийн ширээг заавал ажиллуулах шаардлагагүй. Учир нь эмийн бүтээгдэхүүний баталгаажуулалт нь үйлдвэрлэгчийн цувралын сертификат болон тохирлын гэрчилгээгээр нотлогдоно

/93./ Хугацаа дууссан, хагарч гэмтсэн зэрэг шалтгаанаар хаях эмийн үлдэгдэл хогийг шар өнгийн уутанд цуглуулна. Яагаад гэвэл эмийн сангаас гарах ердийн хог хаягдлыг шар өнгийн тэмдэг бүхий саванд цуглуулдаг.

/94./ Эмийн сангийн ажиллагсад эрүүл мэндийн үзлэгт жилд нэг удаа хамрагдана. Учир нь ажиллагсад нь халдварт өвчнөөр өвчилсөн, салст үрэвссэн, идээт үрэвсэлтэй байж болохгүй

/95./ Эмийн сангийн эм найруулах зориулалтын байранд эмчийн жороор стандарт, фармкопейн дагуу эмийг найруулж бэлтгэнэ. Яагаад гэвэл эмийн сан дотоод бэлдмэлийг өөрийн салбараас бусад байгууллагад нийлүүлэхгүй

/96./ Нөөцийн өрөөнд эм барааг төрөлжүүлэн байрлуулна. Учир нь эмийн физик, химийн шинж чанарт тохируулан найдвартай хадгалах нөхцөл хангасан төхөөрөмж бүхий агуулахтай байх ёстой.

97./ Эмийн санг 3-аас доошгүй жил ажилласан, мэргэшсэн эм зүйч удирдана. Учир нь “Эмийн сангийн стандарт”-д үүнийг заасан байдаг

/98./ Тодорхой нөхцөл, орон зай, хугацаанд явагдаж буй аж ахуйн үйл ажиллагааг тусгаж буй хоорондоо харилцан уялдсан үзүүлэлтүүдийн нийлбэрийг эдийн засгийн хэллэгээр юу гэх вэ?

- A. Үзүүлэлт
- B. Нийлбэр
- C. Систем
- D. Иж бүрдэл
- E. Нэгдэл

/99./ Эмийн сангийн кассаар өдөр тутамд борлуулсан эмийн үнэнд хурааж авсан мөнгийг зөв дүгнэж, хэдий хугацаанд банканд буюу няравт тушаах ёстой вэ?

- A. 24 цагийн дотор
- B. Тэр дор нь
- C. 48 цагийн дотор
- D. 72 цагийн дотор
- E. 7 хоногийн дотор

/100./ Аливаа эмийн сангуудын барааны эргэлтийн хурд нь барааны нөөцөөс ихээхэн хамаарах ба борлуулалтын хэмжээтэй ямар хамааралтай байх вэ?

- A. Бага зэрэг хамааралтай
- B. Нилээд хамааралтай
- C. Урвуу хамааралтай
- D. Шууд хамааралтай
- E. Хамааралгүй

/101./ Эмийн сангийн үнийн дүнгээр тооцоо бодуулдаг жор баригчийн эм бараа материал, сав боодол, туслах материалын ээлжит тооллогыг хэзээ хийх вэ?

- A. Улиралд нэг удаа
- B. Эмийн сангийн эрхлэгчийн тушаалаар
- C. Өөрийн хүсэлтээр
- D. Сар тутам, сар бүрийн эцэст
- E. Хагас жилд

/102./ Эмийн сангийн эргэлтийн бус хөрөнгөнд дараах хөрөнгө орно

- A. Үйлдвэрлэлийн бус үндсэн хөрөнгө
- B. Татварын албанд төлөх төлөөс
- C. Дансанд байгаа бэлэн мөнгө
- D. Нормчлогдох эргэлтийн хөрөнгө
- E. Эм барааны нөөц

/103./ Клиникийн эмнэлгийн эмийн сан нь стационарын жорын төлөвлөгөөг хийжээ. Дараах хувилбаруудын аль сонголтыг ашиглах вэ?

- A. Стационарын жорын борлуулалт = Стационарын жорын тоо x 1 орны тоо
- B. Стационарын жорын борлуулалт = Стационарын жорын тоо x 1 стационарын жорын үнэ
- C. Стационарын жорын борлуулалт = Стационарын жорын тоо x Жилд ашиглах орны тоо
- D. Стационарын жорын борлуулалт = Стационарын орны тоо x 1 стационарын жорын үнэ
- E. Стационарын жорын борлуулалт = Ор хоног x хэвтэн эмчлүүлэгсэдийн тоо

/104./ Дефектар нь хариуцаж байгаа эм барааны нэр төрлийн орлого зарлагын картын үлдэгдлийг хэдий хугацаанд гаргаж ня-бо-той нийлж баталгаажуулах ёстой бэ?

- A. Өдөр тутам
- B. 7 хоног тутам
- C. 14 хоног тутам
- D. сарын эцэст
- E. дараа сарын эхэнд

/105./ Эм хангамжийн байгууллагууд нь ажиллагсадын үндсэн цалингийн доод хэмжээг юуг үндэслэн тогтоох вэ?

- A. Засгийн газраас баталсан цалингийн сүлжээний журмыг
- B. УИХ-ын баталсан цалингийн сүлжээний журмыг

С. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан цалингийн сүлжээний журмыг

D. Байгууллагын удирдлагаас баталсан цалингийн сүлжээний журмыг

E. Мэргэжлийн байгууллагаас баталсан цалингийн сүлжээний журмыг

/106./ Урд оны стационарын жорын тоо мэдэгдэж байгаа нөхцөлд тухайн эмнэлгийн ямар үзүүлэлтийг ашиглан ирэх оны стационарын жорын коэффициентыг олж болох вэ?

A. Эмнэлгийн ор өдрийн тоо

B. Эмнэлгийн ор хоног ашиглалт

C. Амбулаторийн үзлэгийн тоо

D. Стационарын жорын коэффициент

E. Амбулаторийн жорын коэффициент

/107./ Шинээр эмийн сан нээж ажиллуулах тохиолдолд жорын төлөвлөгөөг хэрхэн хийх вэ?

A. жорыг тэр эмийн сантай ойрхон байгаа дүүргийн хүн ам, эмчийн тоо зэрэг бусад үзүүлэлттэй амбулаторийн жорын тоог үндэслэн төлөвлөж болно

B. жорыг тэр эмийн сантай зэрэгцээ байгаа дүүргийн хүн ам, эмчийн тоо зэрэг бусад үзүүлэлттэй амбулаторийн жорын (1 амбулаторийн үзлэгт ноогдох жорын коэффициент) тоог үндэслэн төлөвлөж болно.

C. жорыг тухайн эмийн сангийн үйлчлэх хүн ам, эмчийн тоо зэрэг бусад үзүүлэлттэй амбулаторийн жорын (1 амбулаторийн үзлэгт ноогдох жорын коэффициент) тоог үндэслэн төлөвлөж болно

D. жорыг тухайн эмийн сангийн үйлчлэх хүн ам, эмчийн тоо зэрэг бусад үзүүлэлттэй амбулаторийн жортой харьцуулж төлөвлөж болно.

E. жорыг тухайн эмийн сангийн үйлчлэх хүн ам, эмч, эмийн сангийн тоо зэрэг бусад үзүүлэлттэй амбулаторийн жорын (1 амбулаторийн үзлэгт ноогдох жорын коэффициент) тоог үндэслэн төлөвлөж болно.

/108./ Эм хангамжийн байгууллагуудын нэхэмжлэх, гэрээ, төлөгдсөн чекүүд, бараа материалын биет тооллого зэрэг баримтад тулгуурлан ня-бо дансны бичилтийг гүйцэтгэнэ. Энэ нь нягтлан бодохын ямар зарчим бэ?

A. Бодитой байх зарчим

B. Өртгийн зарчим

C. Материаллаг байх зарчим

D. Бие даасан зарчим

E. Жинхэнэ хэрэгжилтийн зарчим

/109./ Тухайн эм ханган нийлүүлэх байгууллагад бусад байгууллагуудаас шилжин ирэх эм бараануудыг тооллогын үед яах вэ?

A. Тоологдож бүртгэлд тусгагдахгүй

B. Тоологдож бүртгэлд нэгэн адил тусгагдана

C. Тоологдож бүртгэлд оруулахгүй

D. Тоологдож бүртгэлээс тусад нь тооцно

E. Тоологын комисс шийдвэрлэнэ

/110./ Эмийн сан нь бэлэн бус мөнгөний тооцоог хэнтэй хийж болох вэ?

A. Амбулаторийн өвчтөнтэй

B. Эмнэлгийн байгууллагуудтай

C. Эмийн сангийн ажиллагсадтай

D. Салбартай

E. Хэрэглэгчтэй

/111./ Дагалдах баримтгүй ачигдаж ирсэн эм барааг хэрхэн шийдвэрлэх вэ?

A. Буцаана

B. Бүртгэнэ

C. Акт тогтооно

D. Тусад нь бүртгэж хадгална

E. Баримт нь иртэл байлгана

/112./ Эм ханган нийлүүлэх байгууллагаас эмийн санд эм худалдан авсан мөнгөний баримтуудад засвар хийж болох уу?

A. Хориглоно

B. Болно

- С. Эрх бүхий ажилтаны зөвшөөрлөөр болно
 Д. Эрхлэгч баталгаажуулсан тохиолдолд болно
 Е. Банкны мэргэжилтэн зөвшөөрвөл болно
- /113./ Эмийн сангийн жор хүлээн авагч гэнэт солигдох эсвэл ээлжийн амралтаа авах тохиолдолд ямар тооллого хийдэг вэ?
 А. Гэнэтийн
 В. Ээлжит бус
 С. Хяналтын
 Д. Төлөвлөгөөт
 Е. Шалгалтын
- /114./ “Х” эмийн сан жорын төлөвлөлтийг хийхдээ амбулаторийн жорын тоог амбулаторийн үзлэгийн тоонд харьцуулж ямар үзүүлэлтийг тодорхойлж болох вэ?
 А. Амбулаторийн үзлэгийг тооцох коэффициент
 В. Амбулаторийн жорын төлөвлөлтийн коэффициент
 С. Амбулаторийн үзлэгийн төлөвлөлтийн коэффициент
 Д. Амбулаторийн жор ба төлөвлөлтийг тооцох коэффициент
 Е. Амбулаторийн жорыг тооцох коэффициент
- /115./ Эмийн сангийн олсон ашгийг дүрмийн санд оруулсан гэж үзвэл бичилт яаж хийгдэх вэ?
 А. Пассивын дебетед /-/, активын дебетед /+/
 В. Активын кредитэд /-/, пассивын дебетед /+/
 С. Активын дебетэд /-/, пассивын кредитэд /+/
 Д. Пассивын дебетед /+/, активын дебетед /-/
 Е. Пассивын кредитэд /+/, пассивын дебетед /-/
- /116./ “Х” эм ханган нийлүүлэх байгуулах байгууллага өнгөрсөн оны ашигаа тодорхойлжээ. Ашгийг хэрхэн олох вэ?
 А. Худалдааны орлогын дүнгээс зардлын дүнг хасаж
 В. Худалдааны ашгийн дүнгээс зардлын дүнг хасаж
 С. Худалдааны ашгийг зардлын дүнд харьцуулж
 Д. Худалдааны ашгийг зардлын дүнд үржүүлж
 Е. Худалдааны ашгийг зардлаар үржүүлж 100-д хувааж
- /117./ Дараах тэнцлийн аль нь зөв вэ?
 А. Төлбөрийн нэхэмжлэл = төлбөрийн даалгавар
 В. Инкасс = төлбөрийн нэхэмжлэл
 С. Төлбөрийн нэхэмжлэл = аккредитив
 Д. Инкасс = аккредитив
 Е. Аккредитив = төлбөрийн даалгавар
- /118./ “Х” эмийн сангийн худалдааны орлогыг тооцон үзжээ. Дараах хувилбаруудын алийг сонгож бодох вэ?
 А. Худалдааны орлого=Үнэ(жижиглэнгийн)–Үнэ(бөөний)
 В. Худалдааны орлого=Үнэ(жиж.)–Үнэ(бөөний) Зардал
 С. Худалдааны орлого=Ашиг–Зардал
 Д. Худалдааны орлого=Үнэ (бөөний)–Үнэ (жижиглэнгийн)
 Е. Худалдааны орлого=Үнэ(жижиглэнгийн)–Үнэ
- /119./ Эмийн сангийн ажил эхлэх, дуусах, өдрийн завсарлагааны амралтын цагийг хэрхэн шийдэх вэ?
 А. Эмийн сангийн эрхлэгч шийднэ
 В. Байгууллагын дотоод журмаар шийднэ
 С. Хурлаар шийднэ
 Д. Ээлжийн ахлагч шийднэ
 Е. Мэргэжлийн байгууллагын журмаар шийдвэрлэнэ
- /120./ Эмийн санд шингэн тосон эм, ургамлын зүйлүүдийг 100гр хүртэл байнга давтан савлахад хэвийн хорогдлыг хэдэн хувиар тогтоох ёстой вэ?
 А. 1.5%
 В. 2.5%
 С. 3%
 Д. 4%

Е. 5%

/121./ “Х” эмийн сангийн эд хариуцагч А гадаад руу томилтоор яваад ирээгүй байв. Энэ үед тухайн эмийн санд “гэнэтийн ослын” тооллого хийх шаардлага гарав. Ямар шийдвэр гаргах вэ?

- А. Ар гэрээс нь хүмүүсийг тооллогод оролцуулна
- В. Хууль хяналтын байгууллагын ажилтан ба хөндлөнгийн оролцоотой хийнэ
- С. Тооллогыг комисс дангаараа хийнэ
- Д. Эмийн сангийн эрхлэгч тооллогод оролцоно
- Е. Жор баригчийг иртэл нь тооллогыг хүлээнэ

/122./ Эм зүйн байгууллагуудын эдийн засгийн шинжилгээний гол зорилт нь юу вэ?

- А. Хэрэглэгчдэд үнэн зөв мэдээлэл өгөх
- В. Байгууллагын зорилго, зорилтын биелэлтийг хянах
- С. Үйл ажиллагаа нь төлөвлөлттэй уялдаж буй эсэхэд дүгнэлт өгөх
- Д. Үйл ажиллагааны төлөвлөлтийг шинжлэх ухааны үндэслэлтэй бодит болгох
- Е. Удирдлагыг эдийн засгийн мэдээллээр хангах

/123./ Эм хангамжийн байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн үндсэн зорилго нь юу вэ?

- А. Эд хөрөнгийг хянах
- В. Эдийн засгийн шийдвэр гаргахад шаардагдах мэдээллээр шийдвэр гаргагчдыг хангах
- С. Ашгийг үнэн тооцох
- Д. Эм хангамжийн байгууллагуудын тайлан тооцоог гаргах
- Е. Хүмүүсийг эдийн засгийн мэдээллээр хангах

/124./ Эмийн санд нягтлан бодох бүртгэлийн доорх хэлбэрүүд байна

- А. Энгийн данс хөтлөлтийн, баланс гаргах хэлбэр
- В. Статистик бүртгэлийн баланс гаргах хэлбэр
- С. Дебет, кредит гүйлгээний
- Д. Дебет, кредит, баланс
- Е. Дебетийн орлого, зарлага, баланс

/125./ Харилцах банкаар дамжин төлбөрийн даалгавраар, төлбөрийн нэхэмжлэлээр хийгдэх мөнгөний гүйлгээ нь ямар хэлбэртэй вэ?

- А. Бэлэн бус
- В. Бэлэн
- С. Бэлэн, бэлэн бус
- Д. Дансаар
- Е. Төлбөрийн даалгавраар

/126./ Эм барааны эргэлт удааширвал ямар сөрөг үр дагавар гарах вэ?

- А. Эмийн нөөц ихсэнэ
- В. Эргэлтийн хөрөнгө буурна
- С. Эргэлтийн бус хөрөнгө нэмэгдэнэ
- Д. Нормчлогдохгүй хөрөнгө ихсэнэ
- Е. Эмийн нэр төрөл цөөрнө

/127./ Эм найруулагч нь жор хүлээн авагчаас авч туслах материалын бүртгэлд бүртгэгдсэн туслах материалын тайланг хэзээ гаргаж хэнд өгөх ёстой вэ?

- А. Дараа сарын нэгний дотор гаргаж санхүүд өгнө
- В. Сар бүрийн 25-ны дотор гаргаж жор хүлээн авагчид
- С. Сар бүрийн 25 ны дотор гаргаж дефектарт өгнө
- Д. Дараа сарын 5 ны дотор гаргаж дефектарт өгнө
- Е. Дараа сарын 5-н дотор гаргаж жор хүлээн авагчид өгнө

/128./ Дэвсгэр нутгийн хүн амын тоо, үйлчилдэг эмнэлгийн орны тоо нэмэгдэж байгаа нөхцөлд ирэх оны хүлээн авах амбулаторийн жорын тоог ямар үзүүлэлтийг ашиглан төлөвлөж болох вэ?

- А. Ор хоног ашиглалтаар
- В. Амбулаторийн жорын бүтэц
- С. Амбулаторийн үзлэгийн тоогоор
- Д. Амбулаторийн жорын коэффициентоор
- Е. Ор хоног, амбулаторийн жорын коэффициентоор

- /129./ Банканд байгаа эмийн сангийн харилцах данснаас өөр байгууллагад өгөх өрөнд мөнгө шилжүүлээ гэхэд нягтлан бодогч тухайн дансны пассив, актив талд дебет, кредитийн ямар бичилт хийх вэ?
- A. Пассив дебетэд, активын кредитэд
 - B. Активын дебетэд, пассивын кредитэд
 - C. Өглөгийн дансны кредитэд, актив дансны дебетэд
 - D. Активын кредитэд, пассивын дебетэд
 - E. Активыг кредитэд, пассивын кредитэд
- /130./ Баланс дахь хөрөнгийн нийлбэрийн багасалт нь пассив, актив хэсэгт яаж бичигдэх вэ?
- A. Пассивын дебетэд, активын кредитэд
 - B. Пассивын кредитэд, активын дебетэд
 - C. Активын дебетэд, пассивын кредитэд
 - D. Активын кредитэд, пассивын кредитэд
 - E. Пассивын кредитэд, пассивын дебетэд
- /131./ Эмийн сангийн цэвэр ашиг юугаар илэрхийлэгдэх вэ?
- A. Эм борлуулалтаас гүйлгээний зардлыг хассанаар
 - B. Эмийн худалдааны орлогоос гүйлгээний зардлыг хассанаар
 - C. Эм борлуулалтаас зардлыг хассанаар
 - D. Ашигт ажиллагааны түвшинг жижиглэнгээр борлуулсан эм барааны хэмжээгээр үржүүлж 100-д хувааснаар
 - E. Ашигт ажиллагааны түвшинг жижиглэнгээр борлуулсан эм барааны хэмжээнд хувааж 100-аар үржүүлснээр
- /132./ Дараах хувилбаруудын зөвийг сонгоно уу? Хүлээсэн үүрэг, ажил хэргийн явц, үр дүнгийн талаархи санал дүгнэлтээ холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулсан баримт бичгийг юу гэдэг вэ?
- A. Мэдэгдэл
 - B. Илтгэх хуудас
 - C. Тайлан
 - D. Дүгнэлт
 - E. Санал
- /133./ Эмийн сангийн дефектар эм барааны тайланг хэдийд санхүүд өгсөн байх ёстой вэ?
- A. Сар бүрийн 30 ны дотор
 - B. Сар бүрийн 20 ны дотор
 - C. Сар бүрийн 25 ны дотор
 - D. Сар бүрийн 28 ны дотор
 - E. Сар бүрийн 27 ны дотор
- /134./ “Х” эм ханган нийлүүлэх байгууллагын ашигт ажиллагааг тооцов. Дараах хувилбаруудын зөвийг сонгоно уу?
- A. Ашигт ажиллагаа = Худалдааны орлогын түвшин%/ - Зардлын түвшин %/
 - B. Ашигт ажиллагаа = Худалдааны орлогын түвшин - Зардлын түвшин
 - C. Ашигт ажиллагаа = Худалдааны орлого - Зардал
 - D. Ашигт ажиллагаа = Худалдааны орлогын түвшин/жижиглэнгийн үнэ/ - Зардлын түвшин
 - E. Ашигт ажиллагаа = Худалдааны орлогын түвшин/ жижиглэнгийн үнэ / - Зардал
- /135./ Хоёр дансны хооронд гүйлгээ хийгдэж байвал тооцооны ямар хэлбэр гэх вэ?
- A. Ердийн
 - B. Энгийн
 - C. Харьцааны
 - D. Энгийн биш
 - E. Санхүүгийн
- /136./ Эмийн нөөцийн эргэлтийн хурд удаан байвал ашиг ямар байх вэ?
- A. Нөлөөлөхгүй
 - B. Нөлөөлнө
 - C. Бага зэрэг нөлөөтэй
 - D. Төдий чинээ сайн байна
 - E. Төдий чинээ муу байна

/137./ “А” эмийн сан туслах материал, сав боодлыг бараа болгож борлуулжээ. Ямар үйлдэлд орох вэ?

- A. Хөрөнгийн зарлагын үйлдэл
- B. Хөрөнгийн орлого, зарлагын үйлдэл
- C. Хөрөнгийн орлогын үйлдэл
- D. Хөрөнгийн үйлдэл
- E. Эргэлтийн хөрөнгийн үйлдэл

/138./ “Х” эмийн сан жорын стационарын жорын төлөвлөлтийг хийхэд стационарын жорыг тооцох коэффициентыг тооцох шаардлага гаржээ. Дараах хувилбаруудын аль зөв бэ?

A. Стационарын жорыг тооцох коэффициент = стационарын үзлэгийн тоо / жилийн ор хоног ашиглалт

B. Стационарын жорыг тооцох коэффициент = жилийн ор хоног ашиглалт/ стационарын жорын тоо

C. Стационарын жорыг тооцох коэффициент = стационарын жорын тоо / жилийн ор хоногийн тоо

D. Стационарын жорыг тооцох коэффициент = стационарын жорын тоо / жилийн ор хоног ашиглалт

E. Стационарын жорыг тооцох коэффициент = жилийн ор хоногийн тоо/ стационарын жорын тоо

/139./ “Х” эмийн санг тоолох үед тооллогын комиссын гишүүдийн ирц 80 хувьтай байлаа. Тооллогын комиссын гишүүдийн ирц хэдэн хувьтай байх үед тооллогыг эхлэх вэ?

- A. 50 %-аас дээш
- B. 70 %-аас дээш
- C. 80 %-аас дээш
- D. 2/3-аас дээш
- E. 100%

/140./ Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон бүтээгдэхүүний арилжаа, үйлчилгээний явц, тэдгээрт оролцдог хөрөнгө, капитал, өглөгийн өөрчлөлтийн мэдээллийг тухай бүрийн баримтыг үндэслэн эдийн засгийн агуулгаар нь ангилан нэгтгэж бичихийг юу гэх вэ?

- A. Баримт хөтлөлт
- B. Тайлан гаргалт
- C. Нягтлан бодох бүртгэл
- D. Журнал хөтлөлт
- E. Дансны бичилт

/141./ Эмийн эргэлт удааширсан ч хэмжээ нь их байвал эргэлтийн хөрөнгийн хөдөлгөөн яах вэ?

- A. Түргэснэ
- B. Орлого ихсэнэ
- C. Нэмэгдэнэ
- D. Зогсонги байдалтай болно
- E. Орлого буурна

/142./ Эмийн сангийн мөнгөний баримтууд чек, ордерууд, мөнгөний баримт хэн нэгний буруугаас буруу бичигдсэн бол яах вэ?

- A. Засвар хийж баталгаажуулна
- B. Ня-богийн зөвшөөрлөөр тайлбар хийж ашиглана
- C. Хүчингүй болгоно
- D. Эрхлэгчийн цохолтоор нягтлан бодогч засвар хийнэ
- E. Санхүүгийн байгууллагатай тохиролцоно

/143./ Спирт, эфир, хлорформ болон бусад дэгдэмхий органик уусгагчдад хэвийн хорогдлыг хэдэн хувиар тооцох ёстой вэ?

- A. 1%
- B. 1.5%
- C. 2%
- D. 2.5%
- E. 3%

/144./ Эмийн сангийн хөрөнгийг дотор нь

- A. Нормчлогдох, эргэлтийн бус
 - B. Нормчлогдохгүй, үндсэн хөрөнгийн
 - C. Үндсэн хөрөнгө, эргэлтийн, эргэлтийн бус хөрөнгийн
 - D. Үндсэн хөрөнгө, нормчлох
 - E. Нормчлох, нормчлохгүй гэж хуваана
- /145./ Эм бараа борлуулалтын чанарын үзүүлэлтүүдэд ямар үзүүлэлтийг авч үзэж болох вэ?
- A. Эм барааны группын бүтэц
 - B. Эм барааны борлуулалт
 - C. Эм барааны эхний үлдэгдэл
 - D. Эм барааны нөөц
 - E. Тооллогын дүн
- /146./ Эмийн сангийн эргэлтийн хөрөнгө эм барааны балансын тэнцлийн томъёоны аль нь зөв вэ?
- A. $O1 = P + B + O2 - П$
 - B. $O2 = O1 - П + P - B$
 - C. $O2 = O1 + П - P - B$
 - D. $O1 = P - B + O2 - П$
 - E. $O2 = П - P - B - O1$
- /147./ Хөрөнгө нэг байдлаас нөгөөд шилжих тохиолдолд
- A. Нэг дансны активын дебетед, нөгөө нэг дансны пассивын кредитэд
 - B. Нэг дансны пассивын дебетед, нөгөө нэг дансны активын кредитэд
 - C. Нэг дансны активын дебетэд, нөгөө нэг дансны активын кредитэд
 - D. Нэг дансны пассивын кредитэд, нөгөө нэг дансны пассивын дебетэд
 - E. Нэг дансны активын кредитэд, нөгөө нэг дансны пассивын кредитэд бичигдэнэ
- /148./ Тооллого явагдаж байх үеийн өдрийн завсарлага хийх, орой ажил тарах зэрэгт эд хариуцагчийн өрөө тасалгаа агуулахыг хэрхэх вэ?
- A. Битүүмжилна
 - B. Цоожилно
 - C. Лацдана
 - D. Цоожилж, лацдана
 - E. Комиссын дардас дарна
- /149./ Балансын актив талд аж ахуйн ямар үйл ажиллагаа тусгагддаг вэ?
- A. Аж ахуйн хөрөнгийн нөөцийг
 - B. Аж ахуйн хөрөнгийн хөдөлгөөнийг
 - C. Аж ахуйн хөрөнгийн эх үүсвэрийг
 - D. Үйлдвэрлэлийн нөөцийг
 - E. Мөнгөн хөрөнгийн хөдөлгөөнийг
- /150./ "X" Эмийн сангийн эрхлэгчийн тушаалаар тооллогыг явуулжээ. Тооллогын дүнг тооцон үзэхэд 100 кг таван салааны навч урьд сарын дүнгээс дутав. Ургамлын газрын дээрхи хэсгийн түүхий эдэд хэдэн хувийн хорогдол тооцох вэ?
- A. 2,2%
 - B. 1,2%
 - C. 2,0%
 - D. 3,0%
 - E. 4,0%
- /151./ Тогтмол зардлыг тодорхойлно уу?
- A. Түлш
 - B. Зээлийн хүү
 - C. Дээд удирдлагын цалин
 - D. Байрны түрээс
 - E. Ус цахилгаан
- /152./ Эмийн сангийн эргэлтийн хөрөнгийн нөөцийн эзлэх хувь нь ямар байвал зохимжтой вэ?
- A. Дөрөвний гурав нь байвал
 - B. Дөрөвний хоёр нь байвал
 - C. Гуравны хоёр нь байвал
 - D. Аравны найм нь байвал

Е. Хоёрны нэг нь байвал

/153./ “Х” эмийн сан стационарын жорын төлөвлөлтийг хийхэд жилийн ор хоногийг тооцох шаардлага гарчээ. Дараах хувилбаруудын аль зөв бэ?

- А. Жилийн ор хоног = эмнэлгийн орны тоо х ор хоног
- В. Жилийн ор хоног = Төлөвлөсөн ор хоног х эмнэлгийн орны тоо
- С. Жилийн ор хоног = эмнэлгийн орны тоо х жилд ашиглах ор өдөр
- Д. Жилийн ор хоног = жилийн өдөр х эмнэлгийн орны тоо
- Е. Жилийн ор хоног = эмнэлгийн орны тоо х ор хоногийн коэффициент

/154./ Эмийн сангийн нэр төрлөөр тооцорогоо бодуулдаг эмийн агуулах буюу дефектарын хариуцсан эм барааны ээлжит тооллогыг хэзээ хийх вэ?

- А. Сар тутамд
- В. Улиралд нэг удаа
- С. Хагас жилээр
- Д. Эм бараа дутагдсан тохиолдолд
- Е. Гэнэтийн шалгалтын үед

/155./ Улаанбаатар хотын Баянгол дүүрэгт шинээр нийтийн үйлчилгээтэй эмийн сан нээв. Эм бараа борлуулалтыг ашиглан нийт ажилчдийн тоог хэрхэн тооцох вэ? (Борлуулалтыг мян/төг-өөр авна)

- А. А. Нийт ажилчдын тоо = $2.5 + 0,005 \text{ ЭББ/бөөний үнээр/} + 0,02 \text{ ЭББ/жигжиглэнгийн үнээр/}$
- В. В. Нийт ажилчдын тоо = $2,4 + 0,005 \text{ ЭББ/бөөний үнээр/} + 0,03 \text{ ЭББ/жигжиглэнгийн үнээр/}$
- С. С. Нийт ажилчдын тоо = $2,4 + 0,005 \text{ ЭББ/бөөний үнээр/} + 0,02 \text{ ЭББ/жигжиглэнгийн үнээр/}$
- Д. Д. Нийт ажилчдын тоо = $2,4 + 0,006 \text{ ЭББ/бөөний үнээр/} + 0,02 \text{ ЭББ/жигжиглэнгийн үнээр/}$
- Е. Е. Нийт ажилчдын тоо = $2.4 + 0,005 \text{ ЭББ/бөөний үнээр/} + 0.2 \text{ ЭББ/жигжиглэнгийн үнээр/}$

/156./ Барилга, тоног төхөөрөмж зэрэг эм хангамжийн байгууллагуудын бүртгэлийн объектууд нь түүнийг бий болгохтой холбогдон гаргасан зардалтай байхаас гадна эрэлт хэрэгцээг хангаж чадах чадварыг харуулсан зах зээлийн үнэтэй байна. Энэ нь нягтлан бодохын ямар зарчим бэ?

- А. Бодитой байх зарчим
- В. Өртгийн зарчим
- С. Материаллаг байх зарчим
- Д. Бие даасан зарчим
- Е. Жинхэнэ хэрэгжилтийн зарчим

/157./ Эмийн үйлдвэрийн барилга, капсул эм үйлдвэрлэх тоног төхөөрөмж зэрэг нь хөрөнгийн аль ангилалд орох вэ?

- А. Эргэлтийн бус хөрөнгө
- В. Эргэлтийн - биет хөрөнгө
- С. Эргэлтийн – биет бус хөрөнгө
- Д. Эргэлтийн бус – биет бус хөрөнгө
- Е. Эргэлтийн бус - биет хөрөнгө

/158./ Хүчтэй үйлдэлтэй /хорт/ эмийн штанглас нь:

- А. Хар фонон дээр цагаанаар
- В. Цагаан фонон дээр хараар
- С. Цагаан фонон дээр улаанаар
- Д. Улаан фонон дээр цагаанаар
- Е. Улаан фонон дээр хараар бичигдэнэ

/159./ Хугацаат эмийг захиалсан байгууллагад нь мэдэгдэлгүй дарагдуулан хугацааг дуусгасан бол материалын ба моралын хариуцлагыг хэнд хүлээлгэх вэ?

- А. Нийлүүлэгч эмийн бааз
- В. Эмийн сангийн эрхлэгч
- С. Эд хариуцагч
- Д. Худалдааны менежер
- Е. Хангамжийн мэргэжилтэн

/160./ Амбулаторийн жорын тоог, дэвсгэр нутгийн хүн амын тоонд харьцуулбал ямар үзүүлэлтийг гарган авч болох вэ?

- А. Нийт хүн амд ноогдох амбулаторийн жорын тоо
- В. Хүн амд ноогдох амбулаторийн үзлэгийн тоо

- C. Нэг хүнд ноогдох амбулаторийн жорын тоо
D. Нэг хүнд ноогдох стационарын жорын тоо
E. Стационарт байх хоногийн тоо
- /161./ Эмийн сангийн хөрөнгө хариуцдаг, ямар эд хариуцагч хөрөнгийнхөө тооцоог нэр төрлөөр бодуулах вэ?
A. Жор баригч нар
B. Аж ахуйн нярав
C. Мөнгөний нярав
D. Дефектар
E. Салбар эмийн сангийн жор баригч
- /162./ Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын хураамжийг хэдийд цалингаас суутгах вэ?
A. Улиралд
B. Жилд
C. Сар бүрийн урьдчилгаа цалингаас
D. Сар бүрийн эцсийн цалингаас
E. хагас жилд
- /163./ Буруу найруулсан жорын бүртгэлийг хэн хөтлөх ёстой бэ?
A. Эм найруулагч
B. Олгогч шалгагч
C. Жор хүлээн авагч
D. Шинжлэгч
E. Дефектар
- /164./ Бусад байгууллага, хүмүүстэй ямар нэг өглөг авлагын тооцоо байхгүй, тоолуулахад бэлэн болох тухай эд хариуцагч баталгаа гарган гарын үсгээ зурж хэнд өгөх вэ?
A. Эрхлэгчид өгнө.
B. Тооллогын комисст өгнө.
C. Нягтлан бодоход өгнө
D. Байгууллагын удирдлагад өгнө
E. Ээлжийн ахлагчид өгнө.
- /165./ Балансын томъёоны аль нь зөв бэ?
A. Эхний Үлдэгдэл - Орлого = Зарлага – Эцсийн Үлдэгдэл
B. Эхний Үлдэгдэл– +Зарлага = Орлого–+ Эцсийн Үлдэгдэл
C. Эхний Үлдэгдэл + Орлого = Зарлага + Эцсийн Үлдэгдэл
D. Эхний Үлдэгдэл + Зарлага =Орлого – Эцсийн Үлдэгдэл
E. Орлого – Эхний Үлдэгдэл = Зарлага - Эцсийн Үлдэгдэл
- /166./ Хувьсах зардлыг тодорхойлно уу?
A. Түүхий эд
B. Даатгалын хураамж
C. Фирмийн хөлслөн авсан конторын тоног төхөөрөмжийн зардал
D. Зээлийн хүү
E. Цалин
- /167./ “Х” эмийн сан амбулаторийн жорын борлуулалтыг тооцжээ. Дараах хувилбаруудын аль нь зөв вэ?
A. Амбулаторийн жорын тоог 1 амбулаторийн жорын үнээр үржүүлж
B. Амбулаторийн жорын тоог 1 амбулаторийн жорын үнэд харьцуулж
C. Амбулаторийн жорын тоог амбулаторийн үзлэгийн тоогоор үржүүлж
D. Амбулаторийн жорын тоог амбулаторын үзлэгээр үржүүлж, 1 амбулаторийн жорын үнэд харьцуулж
E. Амбулаторийн жорын тоог 1 амбулаторийн жорын үнээр үржүүлж, үзлэгийн тоонд харьцуулж
- /168./ Тооллогоор эд хариуцагчийн эм бараанаас хагарч хэмхэрсэн, ширгэсэн, чанар байдал нь муудсан, хугацаа дууссан эм бараа гарвал ямар шийдвэр гаргах вэ?
A. Тоологдсон зүйлийн ерөнхий дүнгээс хасна
B. Тоологдсон зүйлийн ерөнхий дүнгээс хасаж, тусгай бүлгээр бүртгэл үйлдэнэ.
C. Тоологдсон зүйлийн ерөнхий дүнд оруулан тусгай бүлгээр бүртгэл үйлдэнэ

D. Тоологдсон зүйлийн ерөнхий дүнгээс хасаж, оруулан тусгай бүлгээр бүртгэл үйлдэн актална.

E. Тоологдсон зүйлийн ерөнхий дүнд оруулан актална.

/169./ Нягтлан бодох бүртгэл нь байгууллагын удидлагыг шийдвэр гаргахад онцгой ач холбогдолтой. Учир нь эдийн засгийн тоон мэдээллийг танин мэдэж, мөнгөн нэгжээр тооцон хэмжиж, шинжлэн боловсруулж дүгнэлт, шийдвэр гаргах боломжоор хангадаг мэдээллийн систем юм.

/170./ Эмийн нөөц байнгын эргэлтэнд орж, түүний хурд хэдий чинээ сайн байна, эмийн хангамж, орлого ашиг төдий чинээ сайн байна. Яагаад гэвэл эмийн сангийн эргэлтийн хөрөнгийн гуравны хоёр нь барааны нөөц байна.

/171./ Орлого гэдэг нь бизнесийн нэгжийн худалдан борлуулсан бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил үйлчилгээний үнэ бөгөөд байгууллагын өсөлтийг хангадаг нэг чухал үзүүлэлт юм. Учир нь байгууллагуудын капиталыг нэмэгдүүлэх үндэс болно.

/172./ Хөрөнгө нь балансын тэнцэтгэлийн зүүн гар талд байрладаг. Яагаад гэвэл үүнтэй уялдан хөрөнгийн бүх дансуудын зүүн буюу дебет талд нэмэгдэх өөрчлөлтийг баруун буюу кредит талд хорогдох өөрчлөлтийг тусгадаг.

/173./ Тооллогоор бүх хөрөнгө бараа материал нэг бүрчлэн тоологдож, хэмжигдэж, нүд үзэн тоолох хэрэгтэй. Яагаад гэвэл бөөнөөр савлагдсан баглаа боодолтой эм бараа задлагдсан байж болно

/174./ Барааны хөдөлгөөний хурд, нөөцийн хэмжээ нь хоорондоо шууд хамааралтай байна. Яагаад гэвэл бараа хэдий чинээ хурдан хөдөлгөөнд орно, барааны нөөцийн хэмжээ /хоногоор/ төдий чинээ багасана.

/175./ Зардлыг нягтлан бодох бүртгэлд бүртгэснээр зардлын хэтрэлтэд хяналт тавих, орлого зардлыг харьцуулах, ашгийг хэмжих, мөн цаашдын төлөвлөгөө, төсөл зохиох судалгаа-шинжилгээ хийх, удирдлагын оновчтой шийдвэр гаргах зэрэгт онцгой ач холбогдолтой. Учир нь харин зардал бол борлуулсан бараа, үзүүлсэн үйлчилгээний өртөг болно.

/176./ Эмийн сангийн хүлээн авах жор нь тоогоор болон мөнгөн хэлбэрээр төлөвлөгдөнө. Яагаад гэвэл жор нь эмийн сангийн орон тоо, туслах материалын зардал, ажлын ачаалал, зэрэглэл зэрэг эмийн сангийн эдийн засгийн үзүүлэлтүүдийг төлөвлөхөд хэрэглэгдэнэ.

/177./ Эдийн засгийн мөн чанарыг тодорхойлох үг

A. Нөөц

B. Хэрэгцээ

C. Ховор хомс нөөц

D. Капитал

E. Байгалийн нөөц

/178./ Эм биобэлдмэлийн улсын хяналтыг аймагт явуулах улсын байцаагчийг хэн томилох бэ?

A. Засгийн газар

B. ЭМЯам

C. Хяналтын нэгдсэн алба

D. Аймгийн засаг дарга

E. Орон нутгийн засаг дарга

/179./ Үнийн түвшин өөрчлөгдсөнөөс:

A. Нийлүүлэлт өөрчлөгдөнө

B. Нийлүүлэлтийн хэмжээ өөрчлөгдөнө

C. Нийлүүлэлт хэвээр байна

- D. Нийлүүлэлтийн хэмжээ өөрчлөгдөхгүй
E. Эрэлт өөрчлөгдөнө
- /180./ Барааг худалдан авах үйл ажиллагааг нэмэгдүүлэн урамшуулах маркетингийн урамшууллын иж бүрдэлийн нэг нь :
- A. зарлал чимэглэл
B. борлуулалтын урамшуулал
C. ухуулга
D. биечлэн хийх худалдаа
E. мэдээлэл сурталчилгаа болно.
- /181./ Эмийн хэрэглээнд өвчний хэлбэр, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг аль талаас нөлөөлөл үзүүлэх вэ?
- A. Тооны талаас нь
B. Чанарын талаас нь
C. Аль аль талаас нь
D. Өвчлөл талаас нь
E. Мэдлэгийн түвшин талаас нь
- /182./ Зах зээлд гарч үүрэг зорилтоо гүйцэтгэх, таних тэмдэгтэй барааны тооцоолсон чадварыг юу гэж ойлгох вэ?
- A. Уг барааны хүч чадал
B. Уг барааны тодорхойлолт
C. Уг барааны чанар
D. Уг барааны таних тэмдэг
E. Уг барааны хөдөлгөөн
- /183./ Ханамжийн коэффициент нь 0,5-аас бага байвал хурд ямар байна гэж үзэх вэ?
- A. Хурд удаан
B. Хурд тогтвортой
C. Хурд туйлын удаан
D. Хурд өсөх хандлагатай
E. Хурд маш түргэн
- /184./ Үйлчилгээний бүрэн мөчлөгтэй бөөний худалдаачид нь өөр хоорондоо юугаараа ялгагдах вэ?
- A. барааны нэр төрлийн олон цөөнөөр
B. барааны чанараар
C. барааны хувиарлалтаар
D. барааны үйлдвэрлэлээр
E. барааны хуваарилалтаар
- /185./ Зах зээл дэх хэрэглэгчдийг эмээр хангах ажлын схемийн аль нь зөв вэ?
- A. Эмийн сонголт-нийлүүлэлт- хэрэглээ-түгээлт
B. Эмийн хэрэглээ-сонголт-нийлүүлэлт-түгээлт
C. Эмийн сонголт-түгээлт-эмийн хэрэглээ-нийлүүлэлт
D. Нийлүүлэлт - түгээлт - хэрэглээ - сонголт
E. Нийлүүлэлт - сонголт - хэрэглээ - түгээлт
- /186./ Барааны үнийн бууралтын шалтгаан нь:
- A. Татварын өсөлт
B. Хэрэглэгчийн орлогын өсөлт
C. үйлдвэрлэлийн нөөцийн үнийн бууралт
D. дагалдах барааны үнэ цэнийн бууралт
E. Экспортын татварын бууралт
- /187./ Бүртгэгдсэн өөрийн нэрээр хэрэглээнд гарч буй эмийг ямар эм гэх вэ?
- A. Женерик эм
B. Оригинал эм
C. Оюуны өмчийн эрхийн хамгаалалттай эм
D. А ангилалд багтах эм
E. В ангилалд багтах эм
- /188./ Монгол улсын Үндсэн хуулийн 2-р бүлгийн 16-р зүйлийн 2-д иргэний эрүүл мэндийн талаар юу гэж заасан бэ?

А. Монгол улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй

В. Хүн амын эрүүл мэнд нь төрийн онцгой анхаарал ивээлд байна.

С. Иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламжийг ялгаварлаж гадуурхахгүйгээр тэгш, хүртээмжтэй үзүүлнэ.

Д. Өмчийн төрөл хэлбэрийг харгалзахгүйгээр эрүүл мэндийн байгууллагад адил тэгш хандана.

Е. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагаа нь хүмүүнлэг, энэрэнгүй ёс, ШУ-ны мэдлэг, ололт, орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны аргад тулгуурлана.

/189./ Дараах холимог шингэн эмийг бэлтгэх тооцоо хийнэ үү?

Кодейн 0.12

Натрийн бромид 4.0

Натрийн гидрокарбонат 4.0

Гуа хатны хандмал 5 мл

Бамбайн хандмал 20 мл

Нэрмэл ус 200 мл

А. Паспорт

Кодейн 0.12

Натрийн бромидын 20% уусмал- 40 мл

Натрийн гидрокарбонатын 5% уусмал- 80 мл

Гуа хатны хандмал 5 мл

Бамбайн хандмал 20 мл

Нэрмэл ус 80 мл

В. Паспорт

Кодейн 0.12

Натрийн бромидын 20% уусмал- 20 мл

Натрийн гидрокарбонатын 5% уусмал-80 мл

Гуа хатны хандмал 5 мл

Бамбайн хандмал 20 мл

Нэрмэл ус 100 мл

С. Паспорт

Кодейн 0.12

Натрийн бромидын 20% уусмал- 10 мл

Натрийн гидрокарбонатын 5% уусмал- 40 мл

Гуа хатны хандмал 5 мл

Бамбайн хандмал 20 мл

Нэрмэл ус 150 мл

Д. Паспорт

Кодейн 0.12

Натрийн бромидын 20% уусмал- 20 мл

Натрийн гидрокарбонатын 5% уусмал- 80 мл

Гуа хатны хандмал 5 мл

Бамбайн хандмал 20 мл

Нэрмэл ус 200 мл

Е. Паспорт

Кодейн 0.12

Натрийн бромидын 20% уусмал- 20 мл

Натрийн гидрокарбонатын 5% уусмал- 80 мл

Гуа хатны хандмал 5 мл

Бамбайн хандмал 20 мл

Нэрмэл ус 200 мл

/190./ Хэрэглэгчдийн худалдан авалтыг ямар категороор зааглан авч үзэж болох вэ?

- A. Нарийвчлан төлөвлөсөн худалдан авалт
- B. Нарийвчлан төлөвлөсөн болон төлөвлөөгүй худалдан авалт
- C. Нарийвчлан төлөвлөсөн болон төлөвлөөгүй ба урьдчилан төлөвлөсөн худалдан авалт
- D. Урьдчилан төлөвлөсөн болон нарийвчлан төлөвлөсөн худалдан авалт
- E. Нарийвчлан төлөвлөөгүй хэдийч ямар нэг байдлаар урьдчилан тооцсон худалдан авалт

/191./ Худалдагч олон янзын шинж чанартай, янз бүрийн чимэглэлтэй, өөр өөр чанартай, олон янзаар савлагдсан гэх мэт хоёр буюу хэд хэдэн барааг худалдан борлуулах үйл ажиллагааг

- A. нийтийн маркетинг
- B. барааны ялгавартай маркетинг
- C. зорилтот маркетинг
- D. ирээдүйн эрэлттэй маркетинг
- E. ганцаарчилсан маркетинг гэнэ.

/192./ Эрэлтийн мэдрэмж сайн бол:

- A. Эрэлт буурахад нийт орлого өснө
- B. Үнэ өсөхөд нийт орлого өснө
- C. Үнэ буурахад нийт орлого өснө
- D. Үнэ буурахад нийт орлого буурна
- E. Эрэлт өсөхөд нийт орлого өснө

/193./ Хүмүүсийн хэрэгцээг хангахуйц олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хийхэд шаардлагатай төрөл бүрийн хүчин зүйлсийг хооронд нэгтгэх үйл явцыг

- A. хөдөлмөр
- B. капитал
- C. бүтээгдэхүүн
- D. үйлдвэрлэл
- E. үйлчилгээ гэнэ.

/194./ Үр ашигтай болох нь болон эрүүл мэндэд хор учруулах эрсдэлгүй гэдэг нь шинжилгээний үндсэн дээр нотлогдсон тодорхойлолтыг юу гэж ойлгох вэ?

- A. Эмийн үр ашиг
- B. Эмчилгээний идэвхи
- C. Эмчилгээний хүч чадал
- D. Эмийн аюулгүй байдал
- E. Эмийн тохирсон тунлал

/195./ Монголэмимпекс ХХК үндэсний зайлшгүй шаардлагатай эмийг гадаад зах зээлээс худалдан авах хөрөнгийн эх үүсвэрийг хаанаас авдаг вэ?

- A. Улсын төсвөөс
- B. Эмийн эргэлтийн төвлөрсөн хөрөнгөнөөс
- C. Орон нутгийн төсвөөс
- D. Эрүүл мэндийн яамнаас
- E. Сангийн яамнаас

/196./ Үйлчилдэг эмнэлгүүдэд эмийг хуваарилах коэффициентыг хэрхэн тооцох вэ?

- A. Үйлчилж буй эмнэлгийн орны тоог үйлчилж буй хүрээний эмнэлгийн орны тоонд харьцуулж
- B. Үйлчилж буй хүрээний эмнэлгийн орны тоог үйлчилж буй эмнэлгийн орны тоонд харьцуулж
- C. Үйлчилж буй хүрээний хүн амын тоог эмнэлгийн орны тоонд харьцуулж
- D. Үйлчилж буй өвчтөний тоог эмчилгээ хийлгэх хүний тоонд харьцуулж
- E. Үйлчилж буй өвчтөний тоог курс эмчилгээний эмийн тоонд харьцуулж

/197./ Эм, эмнэлгийн хэрэгсэлийг хэрэглэгчдэд шууд худалддаг эмийн үйлдвэрийг түгээлтийн ямар сувагт багтаан авч үзэх вэ?

- A. Маркетингийн тогтолцоо
- B. Тэг түвшингийн
- C. Нэг түвшингийн
- D. Хоёр түвшингийн

- Е. Гурван түвшингийн
- /198./ Сертификатчиллын системийн дүрмийн дагуу олгогдож, хэрэглэгдэж байгаа, тогтоосон журмын хүрээнд хамгаалагдсан тэмдэгийг юу гэж ойлгох вэ?
- А. Барааны тэмдэг
 - В. Үйлдвэрлэгчийн тэмдэг
 - С. Барааны нэгж
 - Д. Барааны таних тэмдэг
 - Е. Барааны тохирлын буюу чанарын тэмдэг
- /199./ Татвар төлөхгүйгээр бизнес эрхлэх, сул орлого олох, орлого нуун дарагдуулах г.м үйл ажиллагааг
- А. үндэсний орлого
 - В. сүүдэр эдийн засаг
 - С. дотоодын нийт бүтээгдэхүүн
 - Д. үндэсний нийт бүтээгдэхүүн
 - Е. үндэсний цэвэр бүтээгдэхүүн
- /200./ Орлого өсөхөд дагалдах барааны эрэлт:
- А. өснө
 - В. буурна
 - С. хэвээрээ
 - Д. тодорхойлох боломжгүй
 - Е. өргөн хэрэглээний бараанд өснө
- /201./ Эмийн хэрэглээ буурахад нөлөөлөх хүчин зүйл
- А. Хүн амын насны бүлгийн өөрчлөлт
 - В. Эмнэлгийн тусламж ойр дөхөм болох
 - С. Эмийн тусламж ойр дөхөм болох
 - Д. Үйлчилгээний радиус ойртох
 - Е. Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ажил эрчимжих
- /202./ Тодорхой нэг нэрийн эмийн хөдөлгөөний хурд юутай тэнцүү вэ?
- А. $K_x = (Y_{эц} + A_{эм}) : (Y_{эх} + O)$
 - В. $K_x = (Y_{эц} - A_{эм}) : (Y_{эх} + O)$
 - С. $K_x = (Y_{эц} + A_{эм}) : (Y_{эх} - O)$
 - Д. $K_x = (Y_{эц} - A_{эм}) : (Y_{эх} - O)$
 - Е. $K_x = (Y_{эц} + A_{эм}) - (Y_{эх} + O)$
- /203./ Барааг хэрэглэгчидэд ойртуулан хүргэхийн тулд фирм байгууллагууд барааны хадгалалт, тээвэрлэлт болон барааг зөв байршуулах ажлыг зохион байгуулахыг
- А. барааны түгээлт
 - В. барааны суваг
 - С. барааны байршилт
 - Д. барааны хувиарлалт
 - Е. барааны хөдөлгөөн гэнэ.
- /204./ Хүмүүсийн ямар нэгэн зүйл төлбөр хийх хүсэл ба чадварыг илэрхийлдэг нэр томъёо аль нь вэ?
- А. Хэрэгцээ
 - В. Эрэлт
 - С. Шаардлага
 - Д. Хүсэл
 - Е. Сонирхол
- /205./ Хүний хэрэгцээ, эрэлт хоорондоо ялгаатай ойлголт уу?
- А. Ялгаатай
 - В. Ялгаагүй
 - С. Аль нь ч байж болно
 - Д. Тэнцүү
 - Е. Хэрэгцээ нь дутуу
- /206./ Эмийн гадаад худалдааны гэрээ байгуулах үед тусгагдаагүй улс төрийн хямрал, эдийн засгийн хориг, байгалын гамшиг гарснаас болж эмээ авч чадахаа болих нөхцөл тохиолдвол уг нөхцлийг ямар нөхцөл гэх бэ?

- A. Арбитрын
- B. Форс мажорын
- C. Урьдчилсан
- D. Гэрээний дараах
- E. Гэрээнд заагдаагүй

/207./ Үнийн доод түвшинг тогтоосноор:

- A. Хомсдлыг бий болгоно
- B. Эрэлтийг нэмэгдүүлнэ
- C. Нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ
- D. Эрэлт нийлүүлэлт хэвээр байна
- E. Борлуулалтыг нэмэгдүүлнэ

/208./ Эмийн баглаа боодол, өнгө, хэлбэр, үнэ, эм үйлдвэрлэгчидийн ба барааны тэмдэг, тэдний үйлчилгээ гэх мэт бодитой мэдрэгддэг, мэдрэгддэггүй шинж чанаруудын цогцыг маркетингийн ойлголтоор юу гэж ойлгох вэ?

- A. Чанарын баталгаажилт
- B. Эмийн бодлого
- C. Эмийн тодорхойлолт
- D. Эмийн бүтээгдэхүүн
- E. Эмийн чанар

/209./ Эрэлт, нийлүүлэлт, үнэ гэх мэт зах зээлийн элементүүдийн уялдаа холбоо, харилцан үйлчлэлийг юу гэж ойлгох вэ?

- A. Зах зээлийн бололцоо
- B. Зах зээлийн тэнцвэр
- C. Зах зээлийн механизм
- D. Зах зээлийн үйлчилгээ
- E. Зах зээлийн хамаарал

/210./ Маркетингийн төлөвлөлтийн суурь нь:

- A. үйл ажиллагааны төлөвлөлт
- B. бүтцийн төлөвлөлт
- C. бодлогын төлөвлөлт
- D. ашгийн төлөвлөлт
- E. хүн хүчний төлөвлөлт юм.

/211./ Нэг болон олон нийлмэл биологийн идэвхит бодисын бага тунг агуулсан, дотуур, гадуур хэрэглэхэд зориулагдсан янз бүрийн эмийн хэлбэрээр тусгай технологээр үйлдвэрлэгддэг эмийн бэлдмэлүүдийг ямар эмийн бэлдмэл гэх вэ?

- A. Биологийн бэлдмэл
- B. Иммунологийн бэлдмэл
- C. Индефферент бэлдмэл
- D. Гомеопати эмийн бэлдмэл
- E. Синоним эмийн бэлдмэл

/212./ Байгууллагын эдийн засаг санхүүгийн үйл ажиллагааны бие даах чадварын коэффициент 0,6-аас их байвал юуг илтгэх вэ?

- A. Чадвар муу байгааг
- B. Чадварын зохистой харьцааг
- C. Чадвар хангалтгүй байгааг
- D. Чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг
- E. Чадвар унаж байгааг

/213./ Бараа, үйлчилгээний нийлүүлэлт, эрэлт 2 хоорондоо харилцан тэнцэж байгаа байдлыг маркетингийн ухааны үүднээс юу гэж ойлгох вэ?

- A. Эрэлтийн хангалт
- B. Зах зээлийн тогтворжилт
- C. Зах зээлийн тэнцвэр
- D. Хэрэгцээний хангалт
- E. Маркетингийн тооцоо

/214./ Маркетингийн иж бүрэн арга хэмжээ гэдэг нь

- A. ашиг орлого олох боломж
 - B. барааны эрэлтэд нөлөө үзүүлж болох бүх боломж
 - C. үнийг нэг түвшинд барих бололцоо
 - D. үйлдвэрлэлийг өсгөх бүх талын бололцоо
 - E. хуваарилалтыг боловсронгуй болгох боломж
- /215./ Зах зээлийн бараа судлалын судалгаа юунд чиглэх нь зүйтэй вэ?
- A. барааны өртөг
 - B. барааны өрсөлдөх чадвар
 - C. барааны үйлдвэрлэлийн хэмжээ
 - D. ирээдүйн эрэлтийг хангах чадвар
 - E. барааг бүтээх технологи
- /216./ Аж үйлдвэрийн зориулалтай барааны, зуучлах худалдаачдын, улсын албан байгууллагын зах зээл нь маркетингийн ухааны үүднээс зах зээлийн дараах хэлбэрт багтдаг.
- A. хэрэглэгчдийн зах зээлийн
 - B. үйлдвэрийн газрын зах зээл
 - C. төрийн байгууллагуудын зах зээл
 - D. зуучлагч байгууллагуудын зах зээл
 - E. аж үйлдвэр эрхлэгчдийн зах зээл
- /217./ Ямар нэгэн барааг орлуулах бараа их бол түүний эрэлт нь:
- A. Мэдрэмтгий
 - B. Мэдрэмтгий бус
 - C. Нэгж мэдрэмтгий
 - D. 0 мэдрэмжтэй
 - E. Сул мэдрэмжтэй
- /218./ Өрсөлдөх чадварын коэффициент эрэлттэй холбоотой байх ба уг коэффициент 1-ээс их байвал юу гэж ойлгох вэ?
- A. Эрэлт өндөр
 - B. Эрэлт бага
 - C. Эрэлт мэдрэмжтэй
 - D. Эрэлт тогтвортой
 - E. Эрэлт мэдрэмжгүй
- /219./ Эрэлт, үнэ хоёр хоорондоо ямар хамааралтай вэ?
- A. Хамааралгүй
 - B. Тэнцүү
 - C. Шууд
 - D. Урвуу
 - E. Хязгаарлагдмал
- /220./ Эдийн засгийн ажиллагаанд татварын ба улсын зарлагын аргаар нөлөөлөх төрийн үйлдлийг
- A. төрийн бодлого
 - B. төрийн зохицуулалт
 - C. татварын бодлого
 - D. эдийн засгийн бодлого
 - E. сангийн бодлого
- /221./ Эмийн бэлдмэлүүдийг үйлдэлийн механизмаар нь олон улсын хэмжээнд системчилсэн АТС код нь хэдэн шатлалын, хэдэн тэмдгийг агуулах вэ?
- A. 2 шатлалын 6 тэмдгийг
 - B. 3 шатлалын 7 тэмдгийг
 - C. 4 шатлалын 5 тэмдгийг
 - D. 5 шатлалын 7 тэмдгийг
 - E. 6 шатлалын 6 тэмдгийг
- /222./ Хүний хэрэгцээ:
- A. Хязгаарлагдмал
 - B. Хязгааргүй
 - C. Хялбар хангагддаг
 - D. Тухайн нийгмийн хүчин чадалтай тэнцүү

- Е. Хэмжээтэй
- /223./ Маркетингийн ойлголтоор нэг нэрийн эмийн хувьд тодорхойлох ач холбогдлыг аль үзүүлэлт агуулах вэ?
- А. Хэрэгцээ
 - В. Шаардлага
 - С. Хүсэл
 - Д. Эрэлт
 - Е. Шалтгаан
- /224./ Эмийн зах зээл судлалыг дараах байдлаар томъёолж болно
- А. Хэрэглэгчдийн зах зээлийн нэг хэсэг
 - В. Эмийн эрэлт хэрэгцээг солилцооны хүрээнд хангахад чиглэсэн хүмүүсийн үйл ажиллагааны бие даасан төрөл
 - С. Эм, эмнэлгийн хэрэгсэлийг хүн ам, эмнэлгийн байгууллагуудад хүргэх үйл ажиллагаа
 - Д. Зах зээлийн нэгэн төрөл
 - Е. Эм хангамжийн шаардлага
- /225./ Үнэ ихсэх тусам борлуулалт өсч байвал
- А. далд эрэлт
 - В. байнгын эрэлт
 - С. эсрэг эрэлт
 - Д. хэвийн эрэлт
 - Е. эерэг эрэлт гэнэ.
- /226./ Эрэлтийн үнийн мэдрэмж нь 1-ээс их тоо гарч, үнэ өсөхөд нийт орлого яаж өөчлөгдөх вэ?
- А. Өснө
 - В. Буурна
 - С. Тогтмол
 - Д. Яаж ч болно
 - Е. Бага зэрэг өөрчлөгдөнө
- /227./ Нэг төрлийн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ эрхэлдэг хэд хэдэн байгууллагын хоорондох харилцааг юу гэж ойлгох вэ?
- А. түншлэгч
 - В. зуучлагч
 - С. өрсөлдөгч
 - Д. нийлүүлэгч
 - Е. хувиарлагч
- /228./ Хомсдол гэж юу вэ?
- А. үйлдвэрлэлийн хэмжээ буурах
 - В. хүмүүсийн хэрэгцээт бараа дутагдалтай байх
 - С. эрэлтийн хэмжээ нийлүүлэлтийн хэмжээнээс их байх
 - Д. нийлүүлэлтийн хэмжээ багасах
 - Е. гачигдал нь хангагдаагүй байх
- /229./ Бие хүн бараа, ажил, үйлчилгээний өөрт ашигтай аль нэг шинж байдлыг тодорхойлохыг
- А. Харьцаа
 - В. тодорхойлолт
 - С. үнэмшил
 - Д. тусгал
 - Е. үнэлэмж гэнэ
- /230./ Мэдээлэл өгөх чиглэлийн зарлал чимэглэлийг
- А. зах зээлд гарах
 - В. зах зээлд боловсрох
 - С. зах зээлд өсөх
 - Д. зах зээлд унах
 - Е. зах зээлд өрсөлдөх шатанд явуулах нь зүйтэй.
- /231./ Өвчлөлөөр эмийн хэрэгцээ эрэлтийг тооцоход насанд хүрэгсэд болон хүүхдийн эмчилгээ ялгаатай бол хүүхдийг насны бүлгээр нь хэрхэн ангилж авах вэ?

- A. 0-1 хүртэл, 1-5 хүртэл, 5-16 хүртэл гэж ангилна
- B. 0-1 хүртэл, 1-3 хүртэл, 3-5 хүртэл, 5-16 хүртэл гэж ангилна
- C. 0-1, 3-5 хүртэл, 5-14 хүртэл, 15-аас дээш гэж ангилна
- D. 0-3, 3-5 хүртэл, 5-16 хүртэл гэж ангилна
- E. 0-1, 1-5 хүртэл, 5-аас дээш гэж ангилна

/232./ Бараанд дагалдах урьдал болон дараах үйлчилгээ, баталгаа гаргаж өгөх болон барааг дагасан бусад үйлчилгээг маркетингийн ойлголтоор юу гэх вэ?

- A. Стратегийн бараа
- B. Үндсэн бараа
- C. Бодит бараа
- D. Нэмэлт бараа
- E. Хөнгөлөлттэй бараа

/233./ Тодорхой барааг авахад зарим хөнгөлөлт үзүүлэх, ердийн үнээс доогуур үнээр барааг худалдах, үнийн хорогдол тооцох, төрөлжсөн үзэсгэлэн гаргах, судалгаа явуулах зэрэг нь урамшлын иж бүрдэлийн ямар хэрэгсэлд багтах вэ?

- A. Зар сурталчилгаа
- B. Мэдээлэл сурталчилгаа
- C. Борлуулалтын урамшуулал
- D. Борлуулалтын эргэлт
- E. Худалдааны хөнгөлөлт

/234./ Эмийн үнэ нь гэрээний хугацаанд хэвээр байх гэрээг ямар гэрээ гэх вэ?

- A. Дээд хэмжээний үнэтэй гэрээ
- B. Тодорхой бус тоо хэмжээтэй гэрээ
- C. Хоосон зайтай гэрээ
- D. Батлагдсан үнэтэй гэрээ
- E. Тендерийн гэрээ

/235./ Эмийн зах зээлийн зохицуулах чиглэлд аль нь орох вэ?

- A. Эм зүйн тусламж үзүүлэх үйл ажиллагааг магадлан итгэмжлэлээр зөвшөөрөл олгох
- B. Эмтэй харьцах журмын талаар хууль гаргаж мөрдүүлэх
- C. Хууль эрх зүйн актуудын хэм хэмжээнд экспорт, импортыг зохицуулах
- D. Эмийн тусламж үзүүлэх хэмжээ ба чанарын үзүүлэлтүүдийг стандартчилах
- E. Эм зүйн үйл ажиллагааны дүрэм, журам, зааврыг батлан мөрдүүлэх

/236./ Эрэлтийн мэдрэмж муутай барааны үнэ өсөхөд нийт орлого:

- A. Өснө
- B. Буурна
- C. Тогтмол
- D. Хамааралгүй
- E. Бага зэрэг өснө

/237./ Барааны өрсөлдөх чадварын коэффициентийг тооцох томъёоны аль нь зөв бэ?

- A. Худалдсан барааны хэмжээг мөн хугацаанд худалдсан ижил нэрийн барааны хэмжээнд харьцуулж
- B. Худалдсан барааг мөн хугацаанд худалдсан барааны хэмжээнд харьцуулж
- C. Худалдсан барааны нэр төрлийг мөн хугацаанд худалдсан барааны хэмжээнд харьцуулж
- D. Худалдсан ижил нэрийн барааг мөн хугацаанд худалдсан барааны хэмжээнд харьцуулж
- E. Худалдсан барааг мөн хугацаанд худалдсан бараанд харьцуулж

/238./ Нэг худалдагч бүх зах зээлийг ноёрхдог зах зээлийн хэв шинжийг

- A. цэвэр өрсөлдөөний зах зээл
- B. дангаар ноёрхох зах зээл
- C. цөөн тооны дангаар ноёрхогчдын зах зээл
- D. цэвэр онц эрхтэй зах зээл
- E. цэвэр онц эрхтэй өрсөлдөөнт зах зээл гэнэ.

/239./ Зах зээлийн үнийн өрсөлдөөнт тогтцыг:

- A. чөлөөт зах зээлийн эдийн засаг
- B. үнийн уян хатан байдал
- C. үнэ тогтворжилт

- D. ялгаварт үнийн систем
- E. үл ялгаварт үнийн тогтолцоо гэнэ

/240./ Шахмал, туншил, флаконтой эм гэдэг нь уг эм буюу барааны юуг илэрхийлэх вэ?

- A. Барааны тодорхойлолт
- B. Барааны тоон тодорхойлолт
- C. Барааны нэгжийн илэрхийлэл
- D. Барааны тэмдэгийн илэрхийлэл
- E. Барааны хэмжээний илэрхийлэл

/241./ Зах зээл дэх эмийн хангамжийн удирдлага, зохион байгуулалт, бүх төрлийн үйл ажиллагааны үйлдлүүд хосолсоны үр дүнд өвчтөн бүрт хэрэглүүлж байгаа эм нь аюулгүй, үйлчлэлийн идэвх үр нөлөөтэй, хэрэглэхэд тохиромжтой байх тухай ойлголтыг юу гэж ойлгох вэ?

- A. эмийн хангамж
- B. чанарын баталгаажилт
- C. эм зүйн менежмент
- D. эмийн чанар
- E. эмийн бодлого

/242./ Эмийн хэрэглээний интенсив коэффициент гэдэг нь юу вэ?

A. Уг эмээр эмчлэгдсэн өвчтөний тоог сонгож авсан нийт өвчтөний тоонд харьцуулсан үзүүлэлт

- B. Нийт өвчтөний тоог уг эмээр эмчлэгдсэн өвчтөний тоонд харьцуулсан үзүүлэлт
- C. Нийт өвчтөний тоог эмчлэгдсэн өвчтөний тоонд харьцуулсан үзүүлэлт
- D. Эмчлэгдсэн өвчтөний тоог уг эмээр эмчлэгдсэн өвчтөний тоонд харьцуулсан үзүүлэлт
- E. Уг эмээр эмчлэгдсэн өвчтөний тоог эмчлэгдэх өвчтөний тоонд харьцуулсан үзүүлэлт

/243./ Даатгуулагч нь даатгагч нь эрүүл мэндийн байгууллагаас тусламж үйлчилгээ авах, даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

- A. эрүүл мэндийн даатгалын сан
- B. даатгуулагч
- C. даатгагч
- D. даатгалын гэрээ
- E. нийгмийн даатгалын шимтгэлийн сан

/244./ Сануулах чиглэлийн зарлал чимэглэлийг барааны амьдралын мөчлөгийн аль шатанд хийх нь зүйтэй вэ?

- A. зах зээлд гарах
- B. зах зээлд боловсрох
- C. зах зээлд өсөх
- D. зах зээлд унах
- E. зах зээлд өрсөлдөх

/245./ Маркетингийн төлөвлөлт хэдэн үе шатаар явагдах ёстой вэ?

A. Байгууллагын бодит байдалд дүн шинжилгээ хийж, хэтийн төлөвийг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх

B. Зорилгыг тодорхойлж, түүнд хүрэх стратегийг гаргах, хэтийн төлөвийг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх

C. Бодит байдалд дүн шинжилгээ хийж, хэтийн төлөв, зорилго, хүрэх стратегийг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх

D. Байгууллагын стратегийг гаргах, хэтийн төлөвийг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх

E. Зорилгыг тодорхойлж, хэтийн төлөвийг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх

/246./ Зах зээлийн сегментчилэл ихсэх нь импортын бүтээгдэхүүний нэр төрөл олшироход нөлөөлөх үү?

- A. Нөлөөлнө
- B. Нөлөөлөхгүй
- C. Сул нөлөөлнө
- D. Хамааралтай
- E. Өөрчлөлт гарахгүй

/247./ Чөлөөт зах зээл дээр борлуулалт бууралтын хэмжээг юу тодорхойлдог вэ?

- A. Засгийн газар
- B. Эрэлт нийлүүлэлтийн хэмжээний нийлбэр
- C. Эрэлт нийлүүлэлтийн хэмжээний ялгавар
- D. Эрэлт нийлүүлэлтийн хэмжээний аль их нь
- E. Эрэлт нийлүүлэлтийн хэмжээний аль бага нь

/248./ Тодорхой барааг үйлдвэрлэх болон үйлчилгээ явуулахад зайлшгүй шаардлагатай материалын нөөцөөр түншүүд, түүний өрсөлдөгчийг хангагч ажил төрлийн фирм, хувь хүмүүсийг

- A. маркетингийн зуучид
- B. нийлүүлэгч
- C. брокер
- D. түншлэгч
- E. үйлдвэрлэгч гэнэ.

/249./ Эрэлтийн хууль

- A. Эрэлтээс нийлүүлэлт давсан үед үнэ буурна
- B. Хэрэглэгчийн орлого өсөхийн хэрээр худалдаж авах барааны хэмжээ нэмэгдэнэ

- C. Барааны үнэ буурахад худалдан авах хэмжээ нь нэмэгдэхийг харуулна
- D. Зар сурталчилгаа нь худалдааг эрчимжүүлнэ
- E. Бичэгдсэн хууль байхгүй

/250./ Эмийн хэрэглээнд аль хүчин зүйл нь хүчтэй нөлөөлөх вэ?

- A. Өвчлөл
- B. Өвчний бүтэц
- C. Хүн амын насны бүлэг
- D. Соёлын түвшин
- E. Эмийн нэр төрөл

/251./ Байгууллага, хүний эрэлттэй бүтээгдэхүүн, үйлчилгээг бизнесийн хэвшил нийлүүлж, хариуд нь төлбөр авах үйл ажиллагааг маркетингийн ойлголтоор

- A. хүчин зүйлсийн зах зээл
- B. үйлвэрлэлийн зах зээл
- C. бүтээгдэхүүний зах зээл
- D. улсын байгууллагын зах зээл
- E. хэрэглэгчдийн зах зээл

/252./ Эмийн тендерийн саналуудыг нээхэд гишүүдийн ирцийн хувьд ямар зарчим баримтлах вэ?

- A. Бүх гишүүдийг байлцуулна
- B. 70-с дээш хувийн ирцтэй байна
- C. 50-с дээш хувийн ирцтэй байна
- D. 80-с дээш хувийн ирцтэй байна
- E. 90-с дээш хувийн ирцтэй байна

/253./ Сэрүүн нөхцөлд хадгалах эмийн температурын хэлбэлзэл хэдэн градусын хооронд байх вэ?

- A. 0-оос +8 градусын хооронд
- B. 0-оос +5 градусын хооронд
- C. 2-оос +10 градусын хооронд
- D. 8-оос +15 градусын хооронд
- E. 8-аас +10 градусын хооронд

/254./ Барааны хэрэглээний чанарын нийлбэр цогцыг юу гэж ойлгох вэ?

- A. Барааны чанар
- B. Барааны хэрэглээний тодорхойлолт
- C. Барааны хэрэглээний үнэ цэнэ
- D. Барааны хэрэглээний сонголт
- E. Барааны хэрэглээний хангамж

/255./ Барааны таних тэмдэгтэй эм өөрийн зориулалтаараа өвчнийг анагаах, өвчнөөс урьдчилан сэргийлэх эсвэл оношлох үүрэг зорилгоо гүйцэтгэх тооцоолсон чадварыг уг эмийн

- A. барааны тэмдэг
- B. барааны нэгж
- C. барааны тодорхойлолт
- D. чанар
- E. баталгаажилт гэнэ.

/256./ Барааны чанарыг үнэлэх тусгайлсан төрлийн үйл ажиллагааг юу гэж ойлгох вэ?

- A. Барааны экспертиз
- B. Бараа судлалын экспертиз
- C. Барааны нэр төрлийн тодорхойлолт
- D. Барааны чанарын тодорхойлолт
- E. Барааны эрэлтийн тодорхойлолт

/257./ $C_{ij} = a_{ij} \times k_{ij}$ томъёоны a_{ij} - нь ямар үзүүлэлтийг илтгэх вэ?

- A. Шинжээчийн мэргэжлийн тодорхойлолтын үнэлгээ
- B. Эмийн бэлдмэлийн тодорхойлолтын үнэлгээ
- C. Шинжээч (j) - ийн эмийн бэлдмэл (a_i) - д өгсөн үнэлгээ
- D. K - шинжээчийн эмийн үнэлгээ
- E. K - шинжээчийн мэргэжлийн тодорхойлолтын үнэлгээ

/258./ Нэгж бүтээгдэхүүний үнийг багасгахад нийт орлого буурна, яагаад гэвэл үнийг ихэсгэхэд нийт орлого буурч эрэлтийн мэдрэмж муу байна гэж үзнэ.

/259./ Зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрлийн 20%-ийг эзэлдэг эмүүдийг А ангилалд хамааруулна учир нь уг эмүүд хямд үнэтэй тул их хэмжээгээр захиалан авч болно.

/260./ Эмчилгээний зориулалттай хийг хэрэглэж дуусахад баллон даралтгүй болдог. Ийм учраас тээвэрлэх үед цэнэгтэй баллон тээвэрлэхтэй адил нөхцөл шаардлагагүй бөгөөд хамгаалах таг, хажуугийн бөглөө заавал байх албагүй.

/261./ Даатгуулагчид олгох эм нь тухайн эмийн санд ерөнхий нэршлээр байхгүй үед худалдааны нэрээр орлуулан олгож болно. Энэ тохиолдолд Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийн тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан үнийг даатгалын сангаас нөхөн төлөхгүй.

/262./ Тээвэрлэлт хадгалалтын онцгой горим шаардагдах вакцин, биобэлдмэл, оношлуур байдаг бөгөөд тэдгээрээс бусад барааг гаалийн агуулахаас татан авах үүргийг Эмимпэкс концерн хариуцах ба харин вакцин, биобэлдмэл, оношлуурын татан авалт, хадгалалт, тээвэрлэлтийг ХӨСҮТ гүйцэтгэнэ

/263./ Хууль болон гэрээний үндсэн дээр даатгагчид шимтгэл тогтмол төлж эрүүл мэндээ хамгаалах, учирч болох эрсдлийн зардлыг нөхөн төлүүлэхээр даатгуулсан иргэнийг хэлнэ.

/264./ Эмнэлгийн эмийн эмчилгээний хороо нь эмнэлгийн даргаар батлуулсан ажлын нарийвчилсан төлөвлөгөөтэй ажилладаг. Учир нь хорооны үйл ажиллагаанд шаардагдах зардлыг эмнэлгийн байгууллага төсөвтөө тусган санхүүжүүлнэ.

/265./ Гэмт хэрэг зөрчлийн улмаас эрүүл мэндэд нь гэм хор учирсан даатгуулагчийн тусламж үйлчилгээний зардлын төлбөрийг гэм хор учруулсан буруутай этгээдээр төлүүлнэ. Учир нь даатгагч нь эрүүл мэндийн байгууллагад төлөх төлбөрөө 14-с дээш хоногоор хугацаа хожимдуулсан бол уг төлбөрийг нөхөн төлүүлж, хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.1%-тай тэнцэх алданги тооцно.

/266./ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийг эмчилгээний зорилгоор ашиглан журам, нөхцлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Хуульд өөрөөр заагаагүй бол мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх худалдах журмыг тогтоохдоо Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн заалтыг баримтална

/267./ Барааны үнэ нь эрэлттэй шууд хамааралтай байна учир нь үнэ өндөр бол эрэлт бага, үнэ бага бол эрэлт өндөр байна.

/268./ Цэвэр өрсөлдөөний зах зээлийн нөхцөлд эм үйлдвэрлэгч өөрийн үйлдвэрлэсэн эмийн үнийг зах зээлийн үнээс өндөр тогтоож чаддаггүй. Учир нь худалдан авагч нь уг эмийг аль ч эм үйлдвэрлэгчээс зах зээлийн үнээр авах бололцоотой байдаг.

/269./ Лааны сууринд тосон түрхэцийн сууриас ялгагдах ямар өвөрмөц шаардлагууд тавигддаг вэ?

1. Биеийн температурт уусдаг
2. Биеийн температурт хайлдаг.
3. Тасалгааны температурт хатуу
4. Эмийн бодисыг хурдан чөлөөлдөг
5. Зөөлөн консестенцтэй байх

/270./ Өндөр молекулт нэгдэл ба хамгаалагдсан коллойд уусмалыг бэлтгэхэд тэдгээрийн хоёуланд нь байдаг ямар нийтлэг шинж чанарыг тооцох шаардлагатай вэ?

1. Молекулын хэмжээ том байдаг
2. Электролит сөргөөр нөлөөлдөг
3. Дисперсийн системийн төрөл
4. Диффузын хурд бага
5. Зуурамтгай чанар нь өндөр байдаг.

/271./ Дараах шингэнүүдээс аль нь шокийн эсрэг гемодинамикийн шингэнд хамаарагдах вэ?

1. Аминопептидын уусмал
2. Полиглюкин
3. Рингер-Локкын уусмал
4. Реополиглюкин
5. Гемодез

/272./ Фармакопейн заалтын дагуу лааны чанарыг ямар шалгуураар шалгадаг вэ?

1. Уусах хугацаа
2. Нэгэн төрөл
3. Задралт
4. Деформацид бүрэн орох хугацаа
5. Лааны жингийн хэлбэлзэл

/273./ Жоронд эмийн бодисын тун хэтэрсэн тохиолдолд яах вэ?

1. Тусгай тэмдэглэл байвал бэлтгэж болно.
2. Эмийн бодисын нэг удаагийн дээд тунгийн хагасыг олгоно.
3. Мансууруулах бодисын эмийн тунгийн тоог багасгаж олгох нормоос нийлбэр тун нь ихгүй байхаар олгоно.
4. Жорыг олгохгүй.
5. Эмчтэй нь зөвлөж шийднэ.

/274./ Ханасан уурын даралтын дор автоклаваар ямар зүйлүүдийг ариутгаж болох вэ ?

1. Шил, металл, шаазан эдлэл
2. эмний шил, колбо, юүлүүр, уур, нүдүүр
3. Ороох боох зүйлүүд
4. Өндөр температурт тогтвортой бодисын уусмал
5. пергаментэн цаас, халат, хувцас

/275./ Коллойд уусмалын шинж чанарыг нэрлэнэ үү?

1. Гадна байдал нь тунгалаг\солонгорсон\
2. Жижиг хэсгүүд нь цаасан шүүлтүүрээр нэвтэрнэ.
3. Жижиг хэсгүүд нь цаасан шүүлтүүрээр нэвтэрнэ.
4. Жижиг хэсгүүд нь мембранаар нэвтрэхгүй
5. Харьцангуй тогтворгүй

/276./ Цийдмэг эмийн хэлбэрийн давуу талууд:

1. Нэгэн төрлийн байдал
2. Гидрофиль ба липофиль шинж чанартай эмийн бодисуудыг цийдмэгийн найрлаганд оруулах боломжтой

3. Коалесценцийн процесст орох чадвар
4. Дотуур хэрэглэхэд зориулсан цийдмэгээс тос нь хурдан шимэгддэг.
5. Термодинамикийн тогтвортой чанар

/277./ Нийлмэл найрлагатай эмийн бэлдмэлийг бэлтгэхэд үүсч болох физик химийн ба химийн зохисгүй процессууд нь ямар шалтгааны дүнд бий болдог вэ?

1. жорон дахь ингредиентүүдийн тоон харьцаагаар
2. фармакологийн антогонизмаар
3. орчны рН- аар
4. бэлтгэх аргаар
5. Орчны зуурамтгай чанараас

/278./ Хүчтэй суурь, сул хүчлийн үлдэгдлээс тогтсон эмийн бодисыг тогтворжуулахад хэрэглэгддэг бодисыг заах

1. Давсны хүчил
2. Натрийн шүлт
3. Вейбелийн тогтворжуулагч
4. Натрийн гидрокарбонат
5. Этилендиаминтетра-цууны хүчил

/279./ Усыг нэрэхэд бэлтгэх үйл явцыг заана уу.

1. усыг тунгаах
2. усыг зөөлрүүлэх
3. коллойд хольцыг бүлэгнүүлж ялгах
4. аммиакийг холбож цэвэрлэх
5. органик хольцыг задалж цэвэрлэх

/280./ Цийдмэгийн тогтвортой чанарыг шалгахад:

1. 3 хоног хадгалахад үелж салах ёсгүй
2. Минутанд 1500 удаа эргэх центрифугт хийхэд үелж салах ёсгүй.
3. Минутанд 1000 удаа эргэх центрифугт хийхэд үелж салах ёсгүй.
4. 50 С хүртэл халаахад үелж салах ёсгүй.
5. 30 С хүртэл халаахад үелж салах ёсгүй

/281./ Хөвмөл хэлбэрийн тосон түрхцэн дэх эмийн бодисын жижиглэлтийн хэмжээг микроскопын тусламжтайгаар тодорхойлоход дараах шаардлагыг хангасан байх ёстой.

1. Германы фармакопейд тосон түрхцэн дэх эмийн бодисын жижиг хэсгийн хэмжээ 60 мкм-ээс томгүй, нүдний тосон түрхцэнд-50 мкм-ээс томгүй байх ёстой.
2. АНУ-д нүдний тосон түрхцэн дэх эмийн бодисын хэмжээ 50 мкм-ээс томгүй байх ёстой.
3. ОХУ-д тосон түрхцэнд 50 мкм-ээс томгүй хэсгүүд 5%-иас хэтрэхгүй байна
4. Босины аргаар тодорхойлоход 60 мкм- ээс томгүй хэсгүүд 5%-иас хэтрэхгүй байна.
5. Чулковын аргаар тодорхойлоход 60 мкм- ээс томгүй хэсгүүд 3%-иас хэтрэхгүй байна

/282./ Амархан исэлддэг бодисын уусмалыг бэлтгэхдээ

1. шууд олгох шилэнд бэлтгэнэ.
2. шилэн шүүлтүүрээр шүүнэ.
3. халуун нэрмэл усаар сайтар зайлсан хөвөнгөөр шүүнэ
4. шүүлтийн цаас хэрэглэхгүй.
5. шүүлгүйгээр олгоно

/283./ Гетероген тосон түрхэцэд ямар тосон түрхэцүүд хамаарагдах вэ?

1. суспенз хэлбэрийн тосон түрхэц
2. эмульс хэлбэрийн тосон түрхэц
3. хосолсон хэлбэрийн тосон түрхэц
4. уусмал хэлбэрийн тосон түрхэц
5. хайлш хэлбэрийн тосон түрхэц

/284./ Хийн ариутгалын аргад хэрэглэгддэг хиинүүдэд аль нь хамаарагдах вэ ?

1. Этилений оксид
2. пропилений оксид
3. b-пропиолактон
4. полиэтиленоксид
5. пропиленгликоль

/285./ Хордлого тайлах шингэнд дараах шингэнүүдээс аль нь хамаарагдах вэ?

1. рингер локкийн уусмал
2. гемодез
3. аминопептидийн уусмал
4. полидес
5. реополиглюкин

/286./ Хөвмөлийн шинж чанарыг нэрлэнэ үү?

1. Гадна байдал нь тунгалаг
2. Жижиг хэсгүүд нь ультра шүүлтүүрээр нэвтэрэхгүй.
3. Жижиг хэсгүүд нь цаасан шүүлтүүрээр нэвтэрнэ.
4. Гэрлийг ойлгож, хугалсны дүнд сарниулна
5. ердийн микроскопанд харагдахгүй.

/287./ Тосон түрхэцээс эмийн бодис шимэгдэх процессыг сайжруулах сууринд ямар суурь хамаарагддаг вэ?

1. Вазелин
2. Ланолин ургамлын тостой холимог
3. Силиконон суурь
4. Константны эмульсэн суурь ус/ вазелин
5. Загасан тос

/288./ Зуурамтгай шинж чанартай уусгагч бүхий уусмалыг бэлтгэх ямар онцлог байдаг вэ?

1. Жингийн аргаар бэлтгэх
2. Ариутгасан хуурай олгох шилэнд халаах замаар уусгана.
3. Шаардлагатай бол хоёр давхар самбайгаар шүүнэ.
4. Жин-эзэлхүүний аргаар бэлтгэх
5. Халаах шаардлага гардаг учир хуурай шилэнд уусгана.

/289./ Ургамлын түүхий эдээс усан ялгамал бэлтгэхэд ямар шинж чанарыг тооцох ёстой вэ?

1. Түүхий эдийн эсийн бүтэц
2. Үйлчлэгч бодисын физик химийн шинж чанар
3. Дагалдагч болон балласт бодисын физик химийн шинж чанар
4. Шүүх арга
5. Экстрагентын эзэлхүүн

/290./ Тритурацийг бэлтгэхэд туслах чанарын бодисоор яагаад сүүний сахарыг авдаг вэ?

1. Сүүний сахар нь хувийн жингээрээ ихэнх алкалоидын давстай ойролцоо /1.52/
2. Чийг татахгүй
3. Бэлтгэсэн холимог задрахгүй
4. Тун алдагдах тал гарахгүй
5. Удаан хадгалахад ч ялгардаггүй

/291./ Дараах ямар тохиолдолд конденсацын арга нь хөвмөл эмийн хэлбэрийг бэлтгэхэд хэрэглэгддэг вэ?

1. Дисперсийн орчинд эмийн бодис нь уусахгүй тохиолдолд
2. Уусгагчийг солих
3. Уусалтыг сайжруулах
4. Химийн урвалын үр дүнд тунадас үүсэх
5. Коалесценц

/292./ Удаан уусдаг бодисын уусмалыг бэлтгэхдээ дараах аргуудаас алийг нь хэрэглэдэг вэ?

1. эмийн бодисыг жижиглэх
2. уусгах
3. халаах
4. хутгах
5. дэвтээх

/293./ Усан ба спиртэн уусмал бэлтгэх ерөнхий технологийн дүрмэнд аль арга нь хамаарах вэ?

1. Жин эзэлхүүний арга
2. Халаах, шүүх
3. Уусгагчийг эзэлхүүнээр хэмжиж авах арга
4. Эмийн бодисыг жигнэж авсныхаа дараа уусгагчийг нэмэх
5. Хуурай ариутгасан шилэнд уусгах процессыг явуулна.

/294./ Гомоген тосон түрхэцэд ямар тосон түрхэцүүд хамаарагдах вэ?

1. эмульс хэлбэрийн тосон түрхэц
2. хайлш хэлбэрийн тосон түрхэц
3. экстракционы тосон түрхэц
4. уусмал хэлбэрийн тосон түрхэц
5. хосолсон хэлбэрийн тосон түрхэц

/295./ Жин –эзэлхүүний аргаар ямар уусмалуудыг бэлтгэдэг вэ?

1. Усан уусмал
2. Спиртэн уусмал
3. Коллойд уусмал
4. Тосон уусмал
5. Жоронд уламжлалт нэрээр бичигдсэн стандарт шингэн

/296./ Дараах шингэнүүдээс аль нь ус давс ба хүчил шүлтни тэнцвэрийг тохируулдаг шингэнд хамаарагдах вэ?

1. Гемодез
2. Аминопептидын уусмал
3. Реополиглюкин
4. Рингер-Локкын уусмал
5. Полиглюкин

/297./ Урсгал уураар ус, усан уусмалыг эзэлхүүнээс нь хамааруулан хэрхэн ариутгадаг вэ ?

1. 100 мл хүртэл хэмжээтэй бол 30 мин ариутгана
2. 101-500 мл бол 45 мин ариутгана
3. 501-1000 мл бол 60 мин ариутгана
4. 1001-1500 мл бол 75 мин ариутгана.
5. 1500 мл-ээс дээш бол 90 мин ариутгана

/298./ Эмийн сангийн нөхцөлд тарилгын уусмал бэлтгэх технологт аль нь хамаарах вэ?

1. Эмийн бодисыг уусгаж уусмал бэлтгэх
2. Уусмалыг шүүж, механик хольцыг шалгах
3. Шилийг бөглөж хаяглах
4. Уусмалыг ариутгах
5. Уусмалын чанарыг шалгаж бэлэн болгох

/299./ Нунтаг эмийн хэлбэрийн давуу талд аль нь хамаарагдах вэ?

1. жижиглэлтийг зохицуулах боломжтой
2. туслах бодисгүй
3. биологийн үйлчилгээ сайн
4. технологи нь энгийн
5. кристалл бүтцээрээ байгаа эмүүд

/300./ Ургамлын түүхий эдээс үйлчлэгч бодисыг бүрэн гүйцэд хандлахад юу нөлөөлдөг вэ?

1. Түүхий эд экстрагентын харьцаа
2. Диффузын процессын хурд
3. Хандлах дэглэм
4. Усан ялгамлын эзэлхүүн
5. Экстракт-концентратын эзэлхүүн

/301./ Тосон түрхэцийн чанарын шалгуурт аль нь хамаарагдах вэ?

1. Бүрэн деформацид орох хугацаа
2. Нэгэн төрөл байх
3. Хуурай үлдэгдэл
4. Эмийн бодисын жижиг хэсгийн хэмжээ
5. Зуурамтгай чанар

/302./ Чих ба хамрын дуслын тогтвортой уусмал бэлтгэхийн тулд ямар үйлдлийг хийх вэ?

1. Изотоникжуулна.
2. Тогтворжуулагч нэмнэ.
3. Буферийн уусгагч ашиглана.
4. Ариун нөхцөлд бэлтгэнэ
5. Аагтай уусмал ашиглана.

/303./ Хуурай халуун агаараар ямар зүйлүүдийг ариутгаж болох вэ ?

1. Металл, шил, шаазан эдлэл
2. Халуунд тэсвэртэй нунтаг эмийн бодисууд
3. Эрдсийн ба ургамлын тос, ланолин, вазелин, лав
4. Өндөр температурт тогтвортой бодисын уусмал
5. хөвөн, самбай, шүүлтийн цаас, үйсэн ба резинэн бөглөө, пергаментэн цаас,

/304./ Идээшмэл бэлтгэхдээ

1. Усан халаагуур дээр 15 минут халаана
2. 3.3 л хүртэл хэмжээтэй бол усан халаагуур дээр 25 минут халаана.
3. Тасалгааны температурт 45 минут хөргөнө
4. Усан халаагуур дээр 30 минут халаана.
5. Тасалгааны температурт 10 минут хөргөнө.

/305./ Шингэний дуслын жин ямар хүчин зүйлүүдээс хамаардаг вэ?

1. Дуслын тасарч байгаа талбайгаас хамаарна
2. Даралт ихэсвэл дусал хурдан унах бөгөөд бага хэмжээтэй болдог.
3. Даралт багасвал дуслын жин ихэснэ
4. Дуслын жин нь шингэний хувийн жингээс хамаарна.
5. Дуслын жин нь дусаагуур дотор соруулж авсан шингэний их, багаас хамаарна.

/306./ Жинхэнэ уусмалын шинж чанарыг нэрлэнэ үү?

1. Гадна байдал нь тунгалаг
2. Жижиг хэсгүүд нь цаасан шүүлтүүрээр нэвтэрнэ.
3. Жижиг хэсгүүд нь ультра шүүлтүүрээр нэвтэрнэ.
4. Тогтвор сайтай
5. Жижиг хэсгүүд нь мембранаар нэвтэрнэ.

/307./ Хэрэв жоронд тосон түрхэцийн суурийг заагаагүй ба техникийн баримт бичигт тосон түрхэцийн найрлага нь байхгүй байх тохиолдолд суурийг сонгож авахдаа юуг тооцох ёстой вэ?

1. Тосон түрхэцийн хэрэглэх зориулалтаар
2. Дисперсийн системийн төрөл
3. Эмийн бодисуудын физик химийн шинж чанар
4. Эмийн бодисын хэмжээ
5. Эмийн бодисын усанд уусах чанар

/308./ Нунтаг эмийн бодисыг холиход хамгийн түрүүнд уурандаа ямар бодисыг эхэлж авах ёстой вэ?

1. Саармаг чанарын бодисыг авна.
2. Саармаг чанарын бодис байхгүй бол их хэмжээтэй бичигдсэн бодисоос авна.
3. Жижиглэхэд бэрхшээлтэй бодисуудыг эхэнд нь авна.
4. Багаас нь их рүү гэсэн зарчмын дагуу хамгийн бага хэмжээтэй бодисыг эхэлж жижиглэнэ.
5. Талст устай бодисуудыг эхлээд авч хатаана.

/309./ Хөвмөл эмийн хэлбэрийг бэлтгэхэд дисперсийн фазын жижиг хэсгийн хэмжээг багасгахад ямар үйлдлийг хийх ёстой вэ?

1. Нунтагийг жижиглэх
2. Нунтаглах процессыг хурдасгадаг шингэн хэрэглэх
3. Шингэн бодисын оролцоотойгоор нунтаглах
4. Жижиг хэсгийг нэгдүүлэх
5. Фазуудын хоорондын таталцлын хүчийг ихэсгэх

/310./ Усан уусмалыг бэлтгэхэд уусах процессыг хурдасгахад ямар үйлдлийг хийдэггүй вэ?

1. Уусдаг давс үүсгэх процесс
2. Халаах
3. Урьдчилан жижиглэх
4. Хэсэгчилж фракцлах
5. Комплекс нэгдэл үүсгэх

/311./ Тосон уусмалыг тогтворжуулахад хэрэглэгддэг бодисыг заах

1. Na_2SO_3
2. Бутилокситолуол
3. Мерказолил

4. а- токоферол
5. Тиомочевин

/312./ Үрэлд ямар зорилгоор туслах бодисуудыг нэмдэг вэ?

1. үрэл эмэнд жин багтаамж олгох зорилгоор
2. үрэлд уян хатан байдал олгох зорилгоор
3. үрэлд хэлбэр дүрс олгох зорилгоор
4. үрэл эмийн бүрэлдэхүүнд орж байгаа эмийн бодисын үйлчилгээг ихэсгэх зорилгоор
5. үрэл эмийн бүрэлдэхүүнд орж байгаа эмийн бодисын үйлчилгээг хурдасгах зорилгоор

/313./ Амархан исэлддэг бодисын уусмалын тогтворжуулахад хэрэглэгддэг бодисыг заах

1. Вейбелийн тогтворжуулагч
2. Давсны хүчил
3. Этилендиаминтетра-цууны хүчил
4. Натрийн шүлт
5. Натрийн гидрокарбонат

/314./ Усан ялгамал бэлтгэхэд хандлах процессын үндсэн үе шатуудад дараах хүчин зүйлүүдээс аль нь хамаарагдах вэ?

1. Түүхий эдийг норгох / капиллярын шингээлт/
2. Хандлалт явуулах
3. ялгамлыг гоожуулж авах
4. Диализ
5. Десорбц

/315./ Эмульсийн тогтвортой байдалд нөлөөлөх хүчин зүйлүүдэд аль нь хамаарагдахвэ?

1. дисперсийн фазын хэмжээ
2. Дисперсийн фаз ба орчны нягтын ялгаатай байдал
3. Фазуудын хоорондох таталцлын хүч
4. Дисперсийн орчны консистенц
5. эмульсжүүлэгч

/316./ Үл нийцлийг засах ямар арга замууд байж болох вэ?

1. Эмийн бодисыг тохирох фармакологийн аналогоор нь орлуулах
2. Технологийн онцгой үйлдлийг хэрэглэх
3. Нэг эмийн хэлбэрийг нөгөөгөөр нь солих
4. Үл нийцэл үүсгэж байгаа бодисыг хасах
5. Жорноос А ба Б дансны бодисыг тусад нь олгох

/317./ Судсаар хэрэглэдэг тарилгын шингэнийг холиход үүсч болох үл нийцэлд аль нь хамаарагддаг вэ?

1. Адсорбцын үл нийцэл
2. Фармакологийн үл нийцэл
3. Температурын үл нийцэл
4. Физикийн үл нийцэл
5. Агаарын үл нийцэл

/318./ Хөвмөлийн тогтвортой чанар нь дараах хэмжигдэхүүний аль алинтай нь урвуу пропорциональ хамааралтай вэ?

1. Жижиг хэсгийн диаметртай
2. Хүндийн хүчний хурдатгалтай
3. Дисперсийн орчин ба дисперсийн фазын нягтын ялгавартай
4. Орчны зуурамтгай чанартай
5. Дисперсийн фазын шинж чанар

/319./ Лаа эмийн хэлбэрт тавигдах шалгууруудад аль нь хамаарагдах вэ?

1. ердийн температурт хатуу байдалтай.
2. хүний биеийн температурт хайлдаг
3. эмийн бодисыг хурдан чөлөөлдөг байх ёстой
4. хурдан хайлж салст бүрхэвчээр жигд тархдаг.
5. салст бүрхэвчийг цочроох нөлөө үзүүлдэггүй.

/320./ Идээшмэл чанамалын тунг хэрхэн шалгах вэ?

1. Нэг удаагийн тунг олохдоо түүхий эдийн хэмжээг шингэн эмийг хэдэн удаа хэрэглэх тоонд харьцуулж гаргана.

2. Хоногийн тунг шалгахдаа 1 удаагийн тунг хоногт хэрэглэх тоогоор үржүүлнэ
 3. Фармакопейн заалттай харьцуулж үзнэ.
 4. Нэг удаагийн тунг олохдоо бэлдэх ялгамлын нийт эзэлхүүнийг эмийг хэдэн удаа хэрэглэх тоонд харьцуулж гаргана.
 5. Хоногийн тунг шалгахдаа түүхий эдийн хэмжээг хэдэн удаа хэрэглэх тоогоор үржүүлнэ
- /321./ Хөвмөлийн шинж чанарыг нэрлэнэ үү?
1. Гадна байдал нь тунгалаг
 2. Жижиг хэсгүүд нь ультра шүүлтүүрээр нэвтэрэхгүй.
 3. Жижиг хэсгүүд нь цаасан шүүлтүүрээр нэвтэрнэ.
 4. Гэрлийг ойлгож, хугалсны дүнд сарниулна
 5. ердийн микроскопд харагдахгүй.

/322./ Уусгагчийг сонгон авахдаа «төстэй зүйл төстөйдөө» уусна гэсэн дүрмийг баримтална. Иймээс ямар нэгэн бодисыг уусгахад түүнтэй бүтцээрээ ойролцоо уусгагчийг авна.

/323./ Халууруулах бодис гэдэг нь бичил биетний амьдралын явцад үүссэн уураг болон полисахаридууд юм. Халууруулах бодис нь дэгдэмхий учир усны ууртай хамт нэрэгдэж, усны дусалтай хамт хөргөгчинд орж болох аюултай.

/324./ Коллойд уусмал нь дисперсийн фазынхаа ширхэгийн хэмжээгээрээ хөвмөл ба жинхэнэ уусмал хоёрын хооронд байрлана. Иймээс нэвтэрч буй гэрэлд булингартай, ойж буй гэрэлд тунгалаг харагддаг нэгэн төрлийн биш систем юм.

/325./ Эмийн сангийн практикт гадуур хэрэглэгдэх зарим шингэн эмийн хэлбэрийг бэлтгэхэд дэгдэмхий ба дэгдэмхий биш уусгагчийг хэрэглэнэ. Эдгээр уусгагчидад найруулсан уусмалыг усан биш уусмал гэх ба ихэвчлэн хамар чихний дусал, тосон түрхэц, шингэн тос байдалтайгаар гадуур хэрэглэх, булчинд тарих, дотуур хэрэглэхээр бэлтгэнэ.

/326./ Температурыг 50-60°C-д хүргэхэд уураг бүлэгнэж ихэнх бичил биетний амьдрах чадвар алдагдаж 100°C-д ойртоход ихэнх эмгэг үүсгэгч бичил биетэн үхдэг. Яагаад гэвэл зарим вирус (халдварт шарын) ба үсэнцрүүд 100°C-д удаан хугацааны турш тэсвэртэй байх чадвартай байдаг.

/327./ Хөвмөлийн дисперсийн фаз нь шингэн дотор үргэлж хөвж байж чаддаггүй. Учир нь таталцах хүчний нөлөөгөөр сидментацад ордог.

/328./ Ургамлын түүхий эдээс усан ялгамал бэлтгэх нь экстракт концентратаас бэлтгэснээс илүү сайн чанартай байдаг. Яагаад гэвэл үйлчлэгч бодис нь гүйцэд ялгардаг.

/329./ Жинтэй ажиллахдаа туухай ба жигнэх зүйлийг тавгийн голд тавина. Яагаад гэвэл жингийн зүүн тавган дээр туухайг, баруун тавган дээр эмийн бодисыг хийж жигнэнэ.

/330./ Шилэн шүүлтүүрээр шүүхэд уусмалын эзэлхүүн нь хорогддоггүй сайн талтай. Ийм учраас алкалоид, будагч бодис, ферментийн уусмалыг шүүхэд хэрэглэж болохгүй.

/331./ Тарилгын уусмалыг бэлтгэхэд хэрэглэгддэг эмийн бодисууд нь чанарын хувьд фармакопейн шаардлага хангасан химийн цэвэр ба шинжилгээнд зориулсан цэвэр зэрэглэлийн бодисууд байх ёстой. Яагаад гэвэл эмийн бодис нь заавал ямар нэг хольцыг өөртөө агуулсан байдаг.

/332./ Ариутгасан тарилгын нэрмэл усанд тавигддаг чухал шаардлагуудын нэг нь халууруулах бодис агуулаагүй байх явдал юм. Халууруулах бодис нь дэгдэмхий биш учир усны ууртай хамт нэрэгдэхгүй боловч усны дусалтай хамт хөргөгчид дамжин орж болох аюултай.

/333./ Этанолын концентрацыг сулруулахад холимгийн температур нэмэгдэж эзэлхүүн нь багасдаг. Яагаад гэвэл контракцын үзэгдэл явагддаг.

/334./ Антибиотикууд нь исэлдэхэд биологийн идэвх нь сулрах буюу бүрмөсөн алдагдаж өөрчлөгдөнө. Яагаад гэвэл химийн өөрчлөлтийн дүнд тунадас үүсдэг.

/335./ Камфор, фенилсалицилат, терпингидрат, ментол зэрэг устай үл нийцдэг бодисуудыг устай нийцдэг бодисуудтай урьдчилан холино. Учир нь эдгээр нь устай нийцдэггүй.

/336./ 5% ба түүнээс дээш эмийн бодис орсон хөвмөл, цийдмэгийг жингийн аргаар бэлтгэнэ. Хандмал, шингэн экстрактыг бэлэн усан ялгамал дээр нэмнэ.

/337./ Жигд ширхэгтэй нэгэн төрлийн нунтаг бэлтгэхийн тулд нэг шигшүүрээр шигшиж том хэсгүүдээс салгаад түүнийг дараагийн номерын шигшүүрээр шигшиж жижиг хэсгээс нь салгана. Яагаад гэвэл ганц шигшүүрээр шигшихэд жигд ширхэгтэй нунтаг болдоггүй.

/338./ Гадуур ба дотуур хэрэглэх шингэн эмийн хэлбэрийг жин, жин-эзэлхүүний аргаар бэлтгэж, эзэлхүүнээр олгоно. Яагаад гэвэл 5% ба түүнээс дээш эмийн бодис орсон цийдмэгийг аагтай цийдмэг гэнэ.

/339./ Нунтгийн урсах чанар гэдэг тодорхойлолтын хамгийн зөвийг сонгоно уу?

- A. Нунтаг эмийн бодисын урсах чанар
- B. Нунтаг бодисын гоожих чадвар
- C. Нунтаг бодисын янз бүрийн бодистой хамт урсах чадвар
- D. Нунтаг бодис нь өөрийнхөө хүндийн жингээр гоожих чадвар
- E. Тодорхой эзэлхүүнтэй нунтгийн урсах чанар

/340./ Цувралын дугаар гэж юу вэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. Бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй холбогдсон бүх баримт бичгийн дугаар юм.
- B. Дугаарлах хэсгийг тодорхойлж бичсэн зөв ажиллагааны заавар юм
- C. Бүтээгдэхүүний хаяган дээрх цуврал, цувралын бүртгэл, шинжилгээний сертификат зэрэгт бичигдсэн тусгайлан танигддаг тоо буюу үсгээс тогтсон илэрхийлэл юм. Хэсэг бүтээгдэхүүнийг бусад бүтээгдэхүүнээс ялгах зорилгоор тусгайлан тавьсан хяналтын дугаар юм.
- D. Үйлдвэрлэлийн бүх дамжлагыг дамжсан гэдгийг нотолсон дугаар
- E. Эцсийн савлалтаас гадна үйлдвэрлэлийн бүх дамжлагын бүтээглэхүүнийг хамарсан дугаар

/341./ Нүдний хальсан бэлдмэлийн зөв хариултыг сонгоно уу? Зөв хариултыг сонгоно уу?

- A. Зууван хэлбэртэй, 9-6мм-ийн урт, 3.0-4.5мм өргөн, 0.35мм-ийн зузаантай 0.015гр дундаж жинтэй нулимасны шингэнтэй бионийцэлтэй ариутгагдсан эмийн хэлбэр юм.
- B. Тэгш хэлбэртэй, 9-6мм-ийн урт, 3.0-4.5мм өргөн, 0.35мм-ийн зузаантай 0.015гр дундаж жинтэй нулимасны шингэнтэй бионийцэлтэй нүдний эмийн хэлбэр юм.
- C. Зууван хэлбэртэй, 6-9мм-ийн урт, 3.0-4.5мм өргөн, 0.35мм-ийн зузаантай 0.025гр дундаж жинтэй нулимасны шингэнтэй бионийцэлтэй нүдний эмийн хэлбэр юм.
- D. Зууван хэлбэртэй, тэгш өнцөгтэй 9-6мм-ийн урт, 3.0-4.5мм өргөн, 0.35мм-ийн зузаантай 0.015гр дундаж жинтэй нулимасны шигэнтэй бионийцэлтэй нүдний эмийн хэлбэр юм.
- E.

/342./ Хэрэв тусгайлсан заалт байхгүй бол бүрхүүлтэй шахмал эм ямар хугацаанд задрах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. 15мин-с ихгүй
- B. 30мин-с ихгүй
- C. 5мин-с ихгүй
- D. 10мин-с ихгүй
- E. 3 мин-с ихгүй

/343./ Цийдмэг гэдэг тодорхойлолтын аль нь зөв бэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. Хоорондоо үл холилдох 2 шингэнээс тогтсон нэгэн төрлийн бус дисперсийн систем юм
- B. Шингэн орчин доторх хатуу жижиг хэсгүүдээс тогтсон бичил нэгэн төрлийн бус систем юм

- C. Хийн бөмбөлөг жигд тархсан нэгэн төрлийн дисперсын систем юм
D. Дотроо хатуу жижиг хэсгүүд агуулсан хийн холимог юм
E. Шингэн дотор тархсан хий ба хатуу фазуудын холимог
- /344./ Хатуу капсулд глицерин хэдэн хувь агуулагдах вэ? Зөв хариултыг сонгоно уу?
A. 0,2-0,25%
B. 0,3% хүртэл
C. 20-25%
D. 2-5%
E. 0,5% хүртэл
- /345./ Аэрозолийн баллон хэдий хэмжээний илүүдэл даралтыг даах чадвартай вэ? Зөв хариултыг сонгоно уу?
A. 4-5 атм
B. 2-3 атм
C. 5-7 атм
D. 2-8 атм
E. 3-7 атм
- /346./ Контактны хатаагчид аль нь хамаарах вэ?
A. Вакуум хатаагч шүүгээ
B. Шүүгээт хатаагч
C. Вакуум булт хатаагч
D. Туузан хатаагч
E. Өндөр давтамжит цахилгаан гүйдлээр хатаагч
- /347./ Бөмбөлөгт тээрэмд жижиглэх гэж буй материалыг бөмбөлөгүүдийн хамт хийхдээ хүрдний эзлэхүүний хэдэн хувьд хийдэг вэ? Зөв хариултыг сонгоно уу?
A. 60%
B. 30%
C. 40-45%
D. 50%
E. 30-35%
- /348./ Туншилтэй тарилгын уусмалын дүүргэлтийг ямар аргаар шалгах вэ? Зөв хариултыг сонгоно уу?
A. Вакуумны аргаар
B. Хар цагаан дэлгэц дээр үзэх
C. Шприцийн аргаар
D. Ижил хэмжээний уусмалтай харьцуулж
E. Микроскопоор
- /349./ Тун шилний дотор талыг ямар аргаар угаах вэ? Зөв хариултыг сонгоно уу?
A. Химийн
B. Физикийн
C. Тариурын
D. Конденсацын
E. Биологийн
- /350./ Дозаторыг ажиллагаанд хэрэглэхийн өмнө ямар уусмалаар арчиж ариутгах вэ? Зөв хариултыг сонгоно уу?
A. Спирт эфирийн холимгоор
B. Буцалсан усаар
C. Этанолоор
D. Эфирээр
E. Формалинээр
- /351./ Д зэрэглэлийн өрөөнд дараах ажлуудын алийг нь хийх вэ? Зөв хариултыг сонгоно уу?
A. Уусмал найруулах
B. Туншил угаах
C. Дрот угаах
D. Туншил дүүргэх
E. Хувцас солих
- /352./ Нунтгийн асгарах жин гэдэг тодорхойлолтын хамгийн зөвийг сонгоно уу?

- A. Чөлөөтэй асгарах нунтгийн нэгж эзэлхүүн дэх жинг хэлнэ.
- B. Нунтаг бодисын хүндийн жинг хэлнэ
- C. Нунтаг бодисын хувийн жинг хэлнэ
- D. Чөлөөтэй асгарах нунтгийн жинг хэлнэ.
- E. Нунтаг бодисын нягтыг хэлнэ

/353./ Хуурай халуун агаараар ариутгах процесс юунд үндэслэгддэг вэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. Ариутгах камерт хуурай халуун агаар эргэлдэж байхад үндэслэгдэх ба гаднаас агаар орохоос сэргийлэхийн тулд нэмэлт даралтыг камерт барьж байх ёстой.
- B. Ариутгах камераас агаарыг гадагшлуулахад үндэслэгддэг
- C. Ариутгалд хэрэглэгдэж буй уур нь өндөр даралттай байх ёстой
- D. Ариутгах камерт халуун уур оруулахад үндэслэгддэг
- E. Ариутгах камерт халуун агаар оруулах хэрэгтэй

/354./ Мөхлөгжүүлэх процессын зөв тодорхойлолт аль нь вэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. Мөхлөгжүүлэх процесс гэдэг нь шахмал хийх массын урсах чанарыг сайжруулах, үелэхээс сэргийлэх зорилгоор нунтаг эмийн бодисыг тодорхой хэмжээний үр шиг болтол нь томруулах процессыг хэлнэ.
- B. Мөхлөгжүүлэх процесс гэдэг нь шахмал хийх массын урсах чанарыг бууруулан үелэхээс сэргийлэх зорилгоор нунтаг эмийн бодисыг тодорхой хэмжээний үр шиг болтол нь жижиглэх процессыг хэлнэ
- C. Мөхлөгжүүлэх процесс гэдэг нь шахмал хийх массын урсах чанарыг сайжруулах зорилгоор нунтаг эмийн бодисыг томруулах процессыг хэлнэ.
- D. Мөхлөгжүүлэх процесс гэж шахмалын масс хийх нунтаг эмийг үр шиг болтол нь томруулах процессыг хэлнэ.
- E. Мөхлөгжүүлэх процесс гэж шахмалын масс хийх массын урсах чанарыг сайжруулах зорилгоор эмийн бодисыг нунтаглах процессыг хэлнэ.

/355./ Туншилтэй тарилгын уусмалын өнгийг ямар аргаар шалгах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. Микроскопоор харж
- B. Метилен хөхийн уусмалд хийж
- C. Эталон уусмалтай харьцуулж
- D. Нэрмэл устай харьцуулж
- E. Рентген туяаны тусламжтайгаар

/356./ Хатуу биеийг жижиглэх процессын үр дүн нь юугаар илэрхийлэгдэх вэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. Жижиглэсэн материалын жижиглэлтийн ширхэгээр
- B. Жижиглэсний дараах дундаж хэмжээгээр
- C. Материалын жижиглэлтийн зэргээр
- D. Жижиглэхээс өмнөх дундаж хэмжээгээр
- E. Жижиглэлтийн үеийн дундаж хэмжээгээр

/357./ Үйлдвэрийн ердийн гэрэлтүүлэг хэд вэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. 450 люкс
- B. 350 люкс
- C. 300 люкс
- D. 265 люкс
- E. 500 люкс

/358./ Тарилгын зориулалттай нэрмэл усны чанарыг сайжруулах, пироген бодисгүй болгохын тулд технологийн ямар шийдлийг сонгох вэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. Усыг нэрэхдээ 1100-аас дээш температурт, тохиромжтой хурдтайгаар гадаргуугийн усны дусал үүсгэхгүй байхаар явуулна
- B. Уснаас гадаргуугийн идэвхт бодис, менерал давс, хөөс үүсгэгч бодисуудыг урьдчилан зайлуулахгүйгээр тогтмол температурт, тохиромжтой хурдтайгаар гадаргуугийн усны дусал үүсгэхгүй байхаар нэрэлтийг явуулна
- C. Усыг нэрэхдээ менерал давс, хөөс үүсгэгч бодисуудыг урьдчилан зайлуулсны дараа тогтмол температурт, тохиромжтой хурдтайгаар задгай буцалгаж нэрнэ.

D. Уснаас гадаргуугийн идэвхт бодис, менерал давс, хөөс үүсгэгч бодисуудыг урьдчилан зайлуулсны дараа тогтмол температурт, тохиромжтой хурдтайгаар, гадаргуугийн усны дусал үүсгэхгүй байхаар нэрэлтийг явуулна

E. Уснаас гадаргуугийн идэвхт бодис, менерал давс, хөөс үүсгэгч бодисуудыг урьдчилан зайлуулсны дараа тогтмол температурт, тогтмол бус хурдтайгаар нэрэлтийг явуулна.

/359./ Нүдний тосон суурийг жоронд заагаагүй бол, ямар тосон суурь авах вэ?

- A. вазелины тосон суурь
- B. вазелин, ланолины 10:1 харьцаатай тосон суурь
- C. вазелин, ланолины 1:1 харьцаатай тосон суурь
- D. ланолин
- E. силиконы суурь

/360./ Бактерцидны лампыг ажил эхлэхээс хэдэн цагийн өмнө ажиллуулах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. 2-4
- B. 3-4
- C. 1-2
- D. 2-3
- E. 4-6

/361./ Агаарын хэвтээ ламинар урсгалын хурд хэд вэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. 0,35м/сек
- B. 0,65м/сек
- C. 0,25м/сек
- D. 0,45м/сек
- E. 0,15м/сек

/362./ 1-р зэргийн цэвэршилттэй өрөөнд дараах үйлдлүүдийн алийг нь хийх вэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. Туслах материалыг угааж ариутгах
- B. Уусмалыг савлах
- C. Туншил үйлдвэрлэх
- D. Уусмал найруулах

/363./ Дамжин бохирдох гэж юу вэ? Зөв хариултыг сонгоно уу?

A. Нэг бүтээгдэхүүний эхлэл материал, дамжлагын бүтээгдэхүүн эсвэл бэлэн бүтээгдэхүүн нь өөр бүтээгдэхүүний эхлэл материал болон үйлдвэрлэлийн явцын материалаар бохирдохыг хэлдэг

B. Үйлдвэрлэлийн явцад завсрын ба эцсийн бүтээгдэхүүн нь өөр бусад эхний материал ба эцсийн бүтээгдэхүүнээр бохирдохыг хэлнэ

C. Эцсийн савлалт, хаяглалтыг оруулан үйлдвэрлэлийн бүх шатны бохирдолтыг хэлнэ.

D. Эмийн бүтээгдэхүүний чанарын өөрчлөлтийн шалтгаан нь болдог процесс юм

E. Эхний материал, эцсийн савлалт, хаяглалт зэрэг нь үйлдвэрлэлийн бүх бүтээгдэхүүнийг бохирдуулахыг хэлнэ

/364./ Мөхлөгжүүлэх процессын зөв тодорхойлолт аль нь вэ? Зөв хариултыг сонгоно уу?

A. Мөхлөгжүүлэх процесс гэдэг нь шахмал хийх массын урсах чанарыг сайжруулах, үелэхээс сэргийлэх зорилгоор нунтаг эмийн бодисыг тодорхой хэмжээний үр шиг болтол нь томруулах процессыг хэлнэ.

B. Мөхлөгжүүлэх процесс гэдэг нь шахмал хийх массын урсах чанарыг бууруулан үелэхээс сэргийлэх зорилгоор нунтаг эмийн бодисыг тодорхой хэмжээний үр шиг болтол нь жижиглэх процессыг хэлнэ

C. Мөхлөгжүүлэх процесс гэдэг нь шахмал хийх массын урсах чанарыг сайжруулах зорилгоор нунтаг эмийн бодисыг томруулах процессыг хэлнэ.

D. Мөхлөгжүүлэх процесс гэж шахмалын масс хийх нунтаг эмийг үр шиг болтол нь томруулах процессыг хэлнэ.

E. Мөхлөгжүүлэх процесс гэж шахмалын масс хийх массын урсах чанарыг сайжруулах зорилгоор эмийн бодисыг нунтаглах процессыг хэлнэ.

/365./ Ариутгалын дараа туншилний бүрэн бүтэн байдлыг шалгахдаа тун шилтэй уусмалыг ямар уусмалд хийж шалгах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. Савангийн уусмал
- B. Нэрмэл ус
- C. 0.0005% метилен хөхийн уусмал
- D. 0.9% натрийн хлоридын уусмал
- E. Спиртийн уусмал

/366./ Туншилийг Стоксын хууль дээр үндэслэн угаах арга аль нь вэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. Турбовакумын арга
- B. Параконденсацын арга
- C. Вибрацын арга
- D. Хэт авианы арга
- E. Дулааны арга

/367./ Новокайнд тогтворжуулагчийг ямар зорилгоор хэрэглэх вэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. Исэлдэхээс сэргийлж
- B. Тунадасжихаас сэргийлж
- C. Ангижрахаас сэргийлж
- D. Хадгалах хугацааг нь уртасгах
- E. Чанарыг нь хэвээр хадгалах

/368./ Туншилний бүрэн байдлыг шалгахдаа ямар уусмалд хийж шалгах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. Спиртийн уусмалд
- B. Хлорамины уусмалд
- C. Нэрмэл усанд
- D. Метилен хөхийн уусмалд
- E. Фурациллины уусмалд

/369./ Дараах тодорхойлолтын аль нь хамгийн зөв бэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. Хоорондоо үл холилдох 2 шингэн фазаас тогтсон дисперсийн системийг хөвмөл гэнэ.
- B. Шингэн орчин дотор хатуу жижиг хэсгүүд болох дисперсын фазаас тогтсон бичил нэгэн төрлийн бус дисперсын системийг хөвмөл гэнэ
- C. Шингэн дотор хийн бөмбөлөг жигд тархсан дисперсын системийг хөвмөл гэнэ.
- D. Дотроо хатуу жижиг хэсгүүд агуулсан хийн холимогийг хөвмөл гэнэ.
- E. Шингэн дотор тархсан хий ба хатуу фазаудын холимогийг хөвмөл гэнэ.

/370./ Зээрэнцэгт жигдрүүлэгч цагт хэдэн кг тосон түрхэц жигдрүүлдэг вэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. 100-150кг/цаг
- B. 80-120кг/цаг
- C. 50-60кг/цаг
- D. 60-90кг/цаг
- E. 60-80кг/цаг

/371./ Тарилгын зориулалттай уусгагчид тавих шаардлага ямар байх вэ? Зөв хариултыг сонгоно уу?

A. Уусгагч нь маш сайн уусгах чадвартай, хадгалах явцад тогтвор сайтай, физик-химийн хувьд эмийн бодистой харилцан үйлчлэлд ордоггүй, фармакологийн хувьд идэвхгүй, хэрэглэхэд тохиромжтой байхаас гадна үнэ хямдтай байвал тохиромжтой.

B. Уусгагч нь уусгах чадвар сайтай, хадгалах явцад тогтвор сайтай, физик- химийн хувьд эмийн бодистой харилцан үйлчлэлд ордоггүй, фармакологийн хувьд идэвхгүй, амархан хөлддөг, хэрэглэхэд тохиромжтой үнэ хямд байх шаардлагатай.

C. Уусгагч нь маш сайн уусгах чадвартай, хадгалах явцад тогтвор сайтай физик- химийн хувьд эмийн бодистой харилцан үйлчлэлд ордоггүй, фармакологийн хувьд идэвхгүй, хэрэглэхэд тохиромжтой өндөр үнэтэй байх шаардлагатай.

D. Уусгагч нь маш сайн уусгах чадвартай, хадгалах явцад тогтвор сайтай физик- химийн хувьд эмийн бодистой харилцан үйлчлэлд ордог, фармакологийн хувьд идэвхгүй, хэрэглэхэд тохиромжтой үнэ хямд байх хэрэгтэй.

E. Уусгагч нь маш сайн уусгах чадвартай, хадгалах явцад тогтвортой, физик- химийн хувьд эмийн бодистой харилцан үйлчлэлд ордоггүй, фармакологийн хувьд идэвхгүй, өндөр температурт хайлдаг, хэрэглэхэд тохиромжтой үнэ хямд байх хэрэгтэй.

/372./ Нунтгийн шахагдах чадвар гэдэг тодорхойлолтын хамгийн зөвийг сонгоно уу?

- A. Нунтаг эмийн бодисын бат бэх бүтэцтэй систем үүсгэх чадварыг хэлнэ.
- B. Нунтаг бодисын нягтрах чадварыг хэлнэ
- C. Нунтаг эмийн бодисын бат бэх бүтэцтэй, холбоот дисперсийн систем үүсгэх чадварыг хэлнэ.
- D. Нунтаг бодисын янз бүрийн нөхцөлд шахагдах чадварыг хэлнэ.
- E. Нунтаг бодисын янз бүрийн бодистой хамт шахагдах чадварыг хэлнэ.

/373./ Сахарын сироп бэлтгэдэг дээд зэргийн цэвэршилттэй рафинад сахарын агууламж хэдэн хувь байдаг вэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. 25%
- B. 90%
- C. 99,9%
- D. 50%
- E. 75%

/374./ Тусгайлсан заалт байхгүй бол бүрхүүлгүй шахмал ямар хугацаанд задрах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. 30мин-с ихгүй
- B. 10мин-с ихгүй
- C. 15мин-с ихгүй
- D. 5мин-с ихгүй
- E. 3мин-с ихгүй

/375./ Ариун эмийн үйлдвэрлэлийн “Д” зэрэглэлд ажилчдад ямар шаардлага тавих вэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. Үсийг, боломжтой бол сахлыг ил гаргахгүй битүү далдалсан, хамгаалалтын хувцас тэдгээрт тохирсон гутал өмссөн байх
- B. Үсийг, боломжтой бол сахлыг ил гаргахгүй битүү далдалсан, өмд цамцны хослол 1 эсвэл 2 ширхэг байх
- C. Толгойн өмсгөл нь үсийг бүрэн далдалсан байх
- D. Өдөр бүр ариутгасан шинэ хувцас өмсөх
- E. Усанд орсон байх

/376./ Угаагдах коэффициент гэж вэ?

- A. Түүхий эдийн доторх хоосон зай
- B. Жижиглэсэн материалын жижиг хэсгийн хоорондох зай
- C. Түүхий эдийн доторх эвдэрсэн эсийн зэрэг
- D. Түүхий эдийн доторх амьд эсийн тоо
- E. Түүхий эдийн хандлагчийг шингээх чадвар

/377./ Шахмал эмийн үйлдвэрлэлд хэрэглэгддэг туслах бодисын нийт хэмжээ ямар байх ёстой бэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. 5%-иас ихгүй
- B. 7% иас ихгүй
- C. 10% иас ихгүй
- D. 20% иас ихгүй
- E. 25% иас ихгүй

/378./ GMP-н шаардлага хангасан үйлдвэрийн байрны хана тааз ямар байх ёстой вэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. Хана тааз нь гөлгөр ан цавгүй, тэгш өнцөг үүсгээгүй байна.
- B. Хана шалтай, хана таазтай холбогдох хэсэг нь тэгш өнцөг үүсгэсэн байна
- C. Хана тааз нь барзгар гадаргуутай байна
- D. Шал хана таазыг ногооноор будсан байна
- E. Шал хана таазыг модоор хийсэн байна

/379./ Линимент гэж юу вэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. Тасалгааны температурт өөрийнхөө хэлбэрийг хадгалж чаддаг, биеийн температурт хайлдаг тосон эмийн хэлбэр юм
- B. Арьс салст бүрхэвчинд түрхэж хэрэглэдэг, унжралдсан өтгөвтөр консистенцтэй, гадуур хэрэглэдэг, нийлмэл тосон эмийн хэлбэр юм.

С. Харилцан уусдаггүй нарийн жижиглэгдсэн шингэнүүдээс тогтох бөгөөд гадаад байдлаараа нэгэн төрлийн, гадуур, дотуур болон тарилгаар хэрэглэгддэг тосон эмийн хэлбэр юм.

Д. Харилцан уусдаггүй нарийн жижиглэгдсэн шингэнүүдээс тогтох бөгөөд гадаад байдлаараа нэгэн төрлийн, гадуур, дотуур болон тарилгаар хэрэглэгддэг тосон эмийн хэлбэр юм.

Е. Арьс салст бүрхэвчинд шингээн түрхдэг, унжралдсан өтгөвтөр байдалтай, дотуур хэрэглэдэг, туналагдсан тосон эмийн хэлбэр юм.

/380./ Агаарын босоо ламинар урсгалын хурд хэд байдаг вэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. 0,1м/сек
- B. 0,5м/сек
- C. 0,3м/сек
- D. 0,6м/сек
- E. 0,45м/сек

/381./ Ариун бүтээгдэхүүн үйлдвэрлэх агаарын цэвэршилтийн В,С, Д зэрэглэлд хүрэхийн тулд агаарын солилцооны хэмнэл нь хэд байх ёстой вэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. 1 цагт 10-15
- B. 1 цагт 20-с дээш
- C. 1 цагт 15-с дээш
- D. 1 цагт 10 дээш
- E. 1 цагт 5-аас дээш

/382./ Зөв хариулалтыг сонгоно уу?

А. АМБЕГ гэдэг нь хөдөлгөөнтэй ба хөдөлгөөнгүй 2 патроноос тогтсон пропан, кислородны холимогийн тусламжтайгаар дротыг хайлуулан туншилийг гарган авахад зориулсан тоног төхөөрөмж

В. АМБЕГ гэдэг нь хөдөлгөөнтэй 2 патроноос тогтсон пропан кислородны тусламжтайгаар гал гарган дөлөнд нь дротыг хайлуулан туншилийг гарган авахад зориулсан тоног төхөөрөмж

С. АМБЕГ гэдэг нь хөдөлгөөнгүй 2 патроноос тогтсон пропан кислородны тусламжтайгаар гал гарган дөлөнд нь дротыг хайлуулан туншилийг гарган авахад зориулсан тоног төхөөрөмж

Д. АМБЕГ гэдэг нь хөдөлгөөнтэй хөдөлгөөнгүй 2 патроноос тогтсон кислородны тусламжтайгаар гал гарган дөлөнд нь дротыг хайлуулан туншилийг гарган авахад зориулсан тоног төхөөрөмж

Е. АМБЕГ гэдэг нь хөдөлгөөнтэй хөдөлгөөнгүй 2 патроноос тогтсон дротыг хайлуулан шил гарган авахад зориулсан тоног төхөөрөмж

/383./ Зөөлөн капсул хийхийн тулд глицериныг хэдий хэмжээгээр авах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. 0.3% хүртэл
- B. 5 -7% хүртэл
- C. 1-3% хүртэл
- D. 20-25% хүртэл
- E. 2.0.-2.5% хүртэл

/384./ Новокаинд тогтворжуулагчийг ямар зорилгоор хэрэглэх вэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. Исэлдэхээс сэргийлж
- B. Тунадасжихаас сэргийлж
- C. Ангижрахаас сэргийлж
- D. Хадгалах хугацааг нь уртасгах
- E. Чанарыг нь хэвээр хадгалах

/385./ Тарилгын нэрмэл усанд ямар онцгой шаардлага тавьдаг вэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. рН 5.6-6.0
- B. Халууруулах бодисгүй байх
- C. Хадгалах хугацаа урт байх
- D. Хуурай үлдэгдэлгүй байх
- E. Ангижруулагч бодисгүй байх

/386./ Хуурай халуун агаараар ариутгах процесс юунд үндэслэгддэг вэ? Зөв хариултыг сонгоно уу?

A. А. Ариутгах камерт хуурай халуун агаар эргэлдэж байхад үндэслэгдэх ба гаднаас агаар орохоос сэргийлэхийн тулд нэмэлт даралтыг камерт барьж байх ёстой.

B. В. Ариутгах камераас агаарыг гадагшлуулахад үндэслэгддэг

C. С. Ариутгалд хэрэглэгдэж буй уур нь өндөр даралттай байх ёстой

D. D. Ариутгах камерт халуун уур оруулахад үндэслэгддэг

E. E. Ариутгах камерт халуун агаар оруулах хэрэгтэй

/387./ Шулуун гэдэсний капсулын бүрхүүлийг бэлтгэхдээ дараах бодисуудыг ямар харьцаагаар бэлтгэдэг вэ? Зөв хариултыг сонгоно уу?

A. Желатин 20% ,глицерин 10%

B. Желатин 1 хэсэг, глицерин 3хэсэг, ус 5 хэсэг

C. Желатин 3 хэсэг, глицерин 1 хэсэг, ус 5 хэсэг

D. Желатин 70% ,глицерин 30%

E. Желатин 1хэсэг,глицерин 5 хэсэг,ус 4 хэсэг

/388./ Бөмбөлөгт тээрмийн хурд маш их байвал төвөөс зугтах хүч бий болно. Ийм учраас жижиглэх үйл ажиллагаа маш сайн явагдана.

/389./ Тоосруулан хатааж мөхлөгжүүлэх аргаар дулаанд тэсвэр муутай эмийн бодисыг мөхлөгжүүлэхэд хэрэглэнэ. Учир нь энэ үед эмийн бодис өндөр температурын нөлөөнд автагддаггүй давуу талтай

/390./ Ходоод гэдэсний замд амархан задарч байх зорилгоор шахмалд хөвсийлгөгч бодисыг нэмдэг. Учир нь хөвсийлгөгч бодис нь шахмалын бат бөх чанарыг сайжруулдаг.

/391./ Шахмал эмийг чийгтэй мөхлөгжүүлэх аргаар гарган авахдаа хөвсийлгөгч бодисын уусмалыг ашигладаг. Учир нь бат бөх чанартай холбоот дисперсын систем үүсгэхийн тулд цавууг ашигладаг.

/392./ Хэрэв шахмал хийх масс нь норгоход мөхлөг болж чадахаар байвал холбогч бодисоор нэрмэл усыг хэрэглэдэг. Учир нь эмийн бодисыг усаар норгож нойтон масс үүсгээд нойтон мөхлөгжүүлэхэд боломжийн мөхлөг үүсдэг.

/393./ Аэрозоль эмийн хэлбэрийг тээвэрлэх, хадгалахад онцгой нөхцөл шаарддаг. Учир нь цохилтийн хүч, нарны туяаны шууд нөлөө, температурын огцом өсөлт зэрэг хүчин зүйлийн нөлөөгөөр эмийн бодисын үйлдэл буурдаг.

/394./ Гетерогены тосон түрхэцийг бэлтгэх явцад 3 булт тээрмийг ашигладаг. Учир нь энэ тээрэм тосыг жигдрүүлж нэгэн төрлийн болгодог.

/395./ Шахмал хийх массанд холбогч бодисыг их хэмжээгээр нэмж өгөх шаардлагатай. Учир нь холбогч бодисын тусламжтайгаар шахмал эмийн хэлбэрээс эмийн бодис хурдан чөлөөлөгдөж эмчилгээний үйлдлийг сайжруулдаг.

/396./ Сахарын сироп нь осмос даралтаар өндөр байдаг тул микро организмын усыг хатааж, амьдрах орчинг үгүй хийдэг. Ийм учраас 60%-иас бага концентрацтай сиропыг эм зүйн практикт байнга хэрэглэдэг.

/397./ Зарим тарилгын уусмалыг ариутгах үед температурын нөлөөгөөр хими-физикийн өөрчлөлтөнд ордог. Ийм учраас түүнийг тогтворжуулах зорилгоор антиоксидант бодис нэмдэг.

/398./ Уусмалаар ариутгах химийн арга нь уусмалын температураас хамаарахгүй. Учир нь зөвхөн тухайн ариутгагч уусмалын химийн бүтэц, найрлагаас хамаарч ариутгалын процессийн идэвх тодорхойлогдоно.

/399./ Хатах процессын үр дүнд материалд агуулагдах чийг ууршдаг. Учир нь энэ үед агаарын парциаль даралт материалын дотоод даралт 2 тэнцдэг.

/400./ Шулуун гэдэсний капсул эмийн хэлбэрийг биемахбод руу оруулахад эмийн бодис нь шулуун гэдэсний булчингийн ханын даралтын нөлөөгөөр хурдан чөлөөлөгдөн шимэгддэг. Тийм учраас эмчилгээний үйлдэл лааныхаас удаан илэрдэг гэж үздэг.

/401./ Жижиглэх процессын дүнд хатуу биетийн гадаргуугийн талбай ихэсдэг. Тийм учраас бодисыг жижиглэх процессын онолын үндэс нь зөвхөн гадаргуугаар жижиглэгддэг гэж үздэг.

/402./ Шахмал хийх мөхлөгийг шахах үед таталцлын хүч бий болж хоорондоо хэлхэгдэн холбогдож гадаргууд нь нимгэн усан бүрхүүл үүсдэг. Учир нь энэ үед зөвхөн механик хүч үйлчилж байна гэж үздэг.

/403./ Хатуу желатинан капсулыг гарган авахдаа дуслын аргыг хэрэглэдэг. Учир нь тогтмол температуртай желатины уусмалд тэнхлэгээрээ эргэлдэх олон тооны металл хэвийг дүрээд авахдаа капсул хэлбэр үүсгэхэд үндэслэгддэг.

/404./ Бүрхүүл үүсгэгч нь тодорхой хэмжээний бат бөх, уян хатан шинж чанартай байх ёстой. Учир нь бүрхүүлд савлагдсан эмийн чанар байдал, эмчилгээний үр дүн нь бүрхүүлийн шинж чанараас шууд хамаарна.

/405./ Тарилгын эмийн хэлбэрийг бэлтгэхэд хүйтэн аргаар гарган авсан ургамлын шингэн тосыг хэрэглэдэг. Учир нь хүчлийн тоо их байвал мэдрэлийн төгсгөлийг цочроож тарихад өвдөлт үүсгэж болно.

/406./ Шахмал хийх мөхлөгийн чийглэг 2-3% байвал тохиромжтой гэж үздэг. Учир нь чийглэг хэт их бол урсах чанар нь мууддаг, хэт бага бол бат бөх чанар нь мууддаг.

/407./ Бүрхүүл үүсгэгч нь тодорхой хэмжээний бат бөх, уян хатан шинж чанартай байх ёстой. Учир нь бүрхүүлд савлагдсан эмийн чанар байдал, эмчилгээний үр дүн нь бүрхүүлийн шинж чанараас шууд хамаарна.

/408./ Шахмалын гадаад байдлыг сайжруулах зарим хортой, хүчтэй наркотик эмийг ялгах зорилгоор янз бүрийн хүнсний будаг ашигладаг. Учир нь ямарч ялгагдах зүйлгүй бүгд цагаан өнгийн шахмал байх нь тохиромжгүй.

/409./ Мөхлөг нь олон төрлийн фракцын бүрэлдэхүүнтэй байж болохгүй. Учир нь тэдгээр нь үелэн шахмалын дундаж жинд муугаар нөлөөлдөг.

/410./ Хуурай мөхлөгжүүлэх 2 арга байдаг үүний нэг нь эмийн бодисыг куба хэлбэртэй, ижил хэмжээтэй мөхлөг болтол нь шахаж нягтруулаад шахмал эмийн хэлбэрт оруулдаг арга юм. Учир нь энэ үед эмийн бодисын технологийн шинж чанар сайжирдаг.

/411./ Эпидермаль гоюу нь хэсэг газрын үйлчилгээтэй. Учир нь эмийн бодис арьсны гадаргууд нэвчин эмчилгээний үйлдэл үзүүлнэ

/412./ Эмийн бодисыг бие махбодид тодорхой хугацаагаар тогтмол концентрацтай байлгахын тулд матрикс шахмалыг хийдэг. Ийм шахмалыг гарган авахын тулд сараалж үүсгэгч бодисыг ашиглах ба тэдгээрийн дотор биологийн идэвхт бодисыг байрлуулж өгдөг.

/413./ Материал чийгээ алдахдаа гүн капилярт байгаа гигроскопик чийгээ эхлэж алддаг. Учир нь эдгээр чийг нь сул холбоогоор холбогдсон механик агууламжтай чийг байдагтай холбоотой